



Аудитыг гүйцэтгэсэн:	Агуулга	Хуудас
Гүйцэтгэлийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор	Товчилсон үгийн тайлбар	3
	Хүснэгт, зураг, бүдүүвчийн жагсаалт	4
	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5-6
	Ерөнхий мэдээлэл	7-8
	Бүлэг 1. ИНЕГ-ын 2016-2017 оны мөнгөн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт үр ашиггүй байна.	9-13
М.Давааням	ИНЕГ-ын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн тогтолцоо оновчтой бус байна.	9
Аудитын менежер:	“Чингис хаан” ОУНБ-ын Капитал банкнаас улсын төсвийн дансанд шилжүүлсэн навигацийн орлого 63 хоногоор саатуулагджээ.	10-11
З.Ариунзаяа	Хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж ажиллах шаардлагатай байна.	11-13
Чанарын баталгаажуулалтын албаны ахлах аудитор:	Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагыг зохих ёсоор бүртгэж, тайлагнаж иржээ.	13
И.Туяа	Бүлэг 2. Агаарын тээврийг хөгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний үр нөлөө хангалтгүй байна.	14-22
Гүйцэтгэлийн аудитын газрын аудитор:	Агаарын тээвэрлэгч компаниас хүсэлт гаргаагүйгээс нислэгт тэнцэх чадварын гэрчилгээг хүчингүй болгоогүй байна.	14-15
М.Наранжаргал	Ховд нисэх буудлыг дүрмийн шаардлага хангаагүй байхад олон улсын 4С ангиллын аэродромын гэрчилгээжүүлэлт олгосон байна.	15
Стратегийн удирдлагын газрын шинжээч:	“МИАТ” ХК-ийн В-737-800 маягийн агаарын хөлгийн нисэх баг Ховдын аэродромын хөөрч буух зурвасын хөвөөг дайрч эвдрэл үүсгэжээ.	15-16
М.Доржханд	Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн болон агаарын хөлгийн нэгдсэн мэдээлэл бүртгэлгүй байна.	16
Гэрээт ажилтан:	2008 онд коммерийн нисгэгчийн үнэмлэхийг хуурамчаар олгосон байна.	16-17
М.Пүрэвмаа	Ази, Европын чиглэлд дотоодын 3 агаарын тээврийн компани 24 чиглэлд нислэг үйлдэж байна.	17
2018 оны 3 дугаар сар	Иргэний нисэхэд ашиглах агаарын зайн бодлогын баримт бичгийг батлуулах шаардлагатай байна.	17-18
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263755, 261675, 261805 дугаарын утсаар харилцана уу.	Агаарын зайн ашиглалтыг сайжруулах бодлогын хүрээнд олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо өссөн байна.	18-19
	Баруун хэсгийн агаарын замуудад харж удирдах ажиглалтын системгүй байна.	19-20
	Орон нутгийн нисэх буудлын аюулгүй ажиллагаанд тавих хяналт, нисэх буудлын ашиглалтын үр дүн хангалтгүй байна.	20-21
	“Чингис хаан” ОУНБ-ын үлдэх барилга байгууламжийг цаашид хэрхэн шийдвэрлэх асуудал тодорхой бус байна.	21
	Нисэх буудлын ашиглалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгүй, шинээр барьж байгаа аэродромын өртөг өндөр байна.	21-22
	Бүлэг 3. Иргэний нисэхийн салбарын боловсон хүчний зарим үйл ажиллагаа хангалтгүй байна.	23-26
Тайланг УАГ-ын www.audit.mn	2016-2017 онуудад зохион байгуулагдсан зарим сургалт ач холбогдлоо өгч чадаагүй байна.	23-24



цахим хуудаснаас
үзнэ үү.

Хаяг:
Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 6,
Засгийн газрын IY
байр, Үндэсний
аудитын газар

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зарим асуудалд хууль эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна.	25
Үйл ажиллагааны хэтийн болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж ажиллаагүй байна.	25
ИНЕГ-ын бүтэц, орон тоонд тусгагдаагүй албаны үйл ажиллагааг санхүүжүүлж байна.	26
ИНЕГ-ын бүтэц, орон тоонд 2015-2016 онуудад 2 удаа өөрчлөлт хийгджээ.	26
Бүлэг 4. 2016-2017 оны зарим санхүү, эдийн засгийн төлөвлөлт бодитой бус, зардлын гүйцэтгэл үр дүн багатай байна.	27-32
Нийт өр төлбөр өмнөх оноос 11.9 хувиар буурч, урт хугацаат өр төлбөр 40.8 хувиар нэмэгджээ.	27
Санхүүгийн хувьд тогтвортой, төлбөрийн чадвартай байгаа нь өр төлбөрөө барагдуулах боломжтойг харуулж байна.	28-29
Үндсэн хөрөнгийн ашиглалт 0.05 пунктээр сайжирсан байна.	29
Борлуулалтын орлого нэмэгдсэнээр ашигт ажиллагааны түвшин дээшилж, мөнгөн урсгал сайжирчээ.	29-30
Иргэний нисэхийн үйлчилгээний орлого нэмэгдэхэд навигацийн орлогын өсөлт нөлөөлжээ.	30-31
2016-2017 онд нийт батлагдсан төсөвт зардлын 86.9 хувийг ашиглажээ.	31-32
Дүгнэлт	33-34
Зөвлөмж	35
Холбогдох байгууллагын санал	36-41
Саналд өгсөн тайлбар	42-43
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	44-45
Хавсралт № 1-5	46-47
Аудитаар илэрсэн зөрчлийн хуудас	48-51

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

ААНХХ	Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтэс
АСЕМ	Asia-Europe meeting буюу Ази Европын орнуудын дээд хэмжээний чуулга уулзалт
БНМАУ	Бүгд найрамдах Монгол ард улс
БНХАУ	Бүгд найрамдах Хятад ард улс
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГТН	Гэрээний тусгай нөхцөл
ЗГ	Засгийн газар
ЗГАЭЗБТХ	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
ЗТАЖА	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам
ЗТС	Зам, тээврийн сайд
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ЗТЯ	Зам, тээврийн яам
ЗУГ	Захиргаа, удирдлагын газар
ИНД	Иргэний нисэхийн дүрэм
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИНТХ	Иргэний нисэхийн тухай хууль
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУИХ	Монгол Улсын Их Хурал
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НААХЗА	Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба
НААХЗГ	Нислэгийн аюулгүй ажиллагаа, хяналт, зохицуулалтын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НТОЗШША	Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба
ОУИНБ	Олон улсын иргэний нисэхийн байгууллага
ОУНБ	Олон улсын нисэх буудал
ОХУ	Оросын Холбооны улс
СС	Сангийн сайд
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СУГ	Стратегийн удирдлагын газар
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТИНСББ	Төрөөс иргэний нисэхийн салбарт баримтлах бодлого
УБ	Улаанбаатар
УЦУОШГ	Ус, цаг уур, орчны шинжилгээний газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани
ХНХХ	Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
ХТХ	Хөдөлмөрийн тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТТХ	Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
ЧБА	Чанарын баталгаажуулалтын алба
ICAO	International Civil Aviation Organization буюу Олон улсын иргэний нисэхийн байгууллага

**Хүснэгтийн жагсаалт**

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	ИНЕГ-ын 2016, 2017 оны орлого, зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл /сая төгрөг/	9
Хүснэгт 2	Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ сунгагдаагүй судалгаа	14
Хүснэгт 3	Санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн бүрэлдэхүүний динамик шинжилгээ /сая төгрөг/	27
Хүснэгт 4	Төлбөрийн чадварын шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар	28
Хүснэгт 5	Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар	28
Хүснэгт 6	Эргэцийн шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар	28
Хүснэгт 7	Хөдөлмөрийн бүтээмжийн шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар	29
Хүснэгт 8	Үндсэн хөрөнгийн ашиглалтын шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар	29
Хүснэгт 9	Ашигт ажиллагааны шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар	29
Хүснэгт 10	Мөнгөн урсгалын шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар	30
Хүснэгт 11	ИНЕГ-ын 2016-2017 оны орлогын бүтэц /сая төгрөг/	30
Хүснэгт 12	Олон улсын өнгөрөлтийн нислэгийн мэдээ	31
Хүснэгт 13	ИНЕГ-ын 2016-2017 оны зардлын төлөвлөлт, гүйцэтгэл /сая төгрөг/	31

Дүрслэл, бүдүүвчийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Дүрслэл 1	ИНЕГ-ын сүүлийн 10 жилийн байдлаарх нийт орлого, төсөвт төвлөрүүлсэн навигацийн орлого, нийт орлогын дүнд эзлэх хувь	8
Дүрслэл 2	2016-2017 оны VII-XII саруудын өнгөрөлтийн нислэгийн харьцуулалт	19
Дүрслэл 3	2016-2017 оны VII-XII саруудын олон улсын буулт, хөөрөлтийн харьцуулалт	19
Бүдүүвч 1	ИНЕГ-ын зохион байгуулалтын бүтэц	8

Зургийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Зураг 1	Хөөрч буух зурвас баруун ирмэгийн гэмтэл	16
Зураг 2	Зурвасын баруун гар тал уруу гарсан байдал	16
Зураг 3	Хоёрдогч радиолокаторын бүрхэлтийн зураг	20
Зураг 4	ADS-B системийн бүрхэлтийн зураг	20

Хавсралтын жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Хавсралт 1	Агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагыг гэрчилгээжүүлсэн судалгаа.	44
Хавсралт 2	Монгол Улсад арилжааны зорилгоор агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах гадаадын агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлсэн судалгаа.	44-45
Хавсралт 3	Агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлтийн нэгтгэсэн судалгаа	45
Хавсралт 4	Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ эзэмшигч байгууллага, агаарын хөлгийн судалгааны нэгтгэл	45
Хавсралт 5	2007-2017 оны хооронд агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх гэрчилгээжүүлэлтийг нэгтгэсэн судалгаа	45
Хавсралт 6	Аудитаар илэрсэн зөрчлийн хуудас	46-49

**Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл****Аудит хийх үндэслэл:**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2018 онд нийлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016-2017 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд дараах чиглэлээр аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын гол зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудыг дэвшүүлж, хэрэгжүүлсэн.

-  *Мөнгөн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт үр нөлөөтэй байгаа эсэх*
-  *Агаарын тээврийг хөгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр нөлөөтэй байгаа эсэх*
-  *Иргэний нисэхийн салбарын боловсон хүчний зарим үйл ажиллагаа үр нөлөөтэй байгаа эсэх*
-  *Иргэний нисэхийн 2016-2017 оны зарим санхүү, эдийн засгийн төлөвлөлт, гүйцэтгэл үр дүнтэй байгаа эсэх*

Хамрах хүрээ:

Аудитыг ИНЕГ-ын 2016-2017 оны зарим үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт, үр дүн, тайлагналтай холбоотой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт, мэдээлэл холбогдох тооцоолол, судалгаа, байгууллага хоорондын гэрээ, хэлэлцээр, үйл ажиллагааны стратеги болон санхүүгийн тайланд хийсэн дүн шинжилгээ, бусад баримт, мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэв.

Аудитын дэд зорилтод хамаарах асуудлын хүрээнд Зам, тээврийн хөгжлийн яамны холбогдох албад, ИНЕГ-ын 2 алба, 2 газар, 12 хэлтэс, 3 нэгж, зарим нисэх буудлын үйл ажиллагааг шалгасан. Аудитын дэд зорилт, асуудлын шинжилгээнд тусгагдаагүй бусад чиглэлээр болон бүрэн хэмжээгээр үйл ажиллагааг үнэлж, дүгнэх зорилго агуулаагүй болно.

Аудитын хамрах хүрээ нь ИНЕГ-ын 2016-2017 оны үйл ажиллагааг тусгасан боловч шалгаж буй асуудлын онцлог байдлаас шалтгаалан тодорхой асуудлаар өмнөх онуудын үйл явдал, анхан шатны баримт, данс тооцоо холбогдох мэдээллийг нэмж шалгалаа.

Аудитын арга зүй:

Аудитыг Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан гүйцэтгэлийн аудитын журмыг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, асуулга, судалгаа авах, мэдээ, тайланг судалж, санхүүгийн тайлангийн болон нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, ажлын баримт боловсруулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Хүндрэл, бэрхшээл:

Аудитын урьдчилсан судалгааны явцад хэрэгжүүлсэн горим, дүн шинжилгээ, ярилцлагын явцад тодорхойлогдсон эрсдэлийн үнэлгээнд өөрчлөлт ороогүй болно.

**Аудитад ашигласан шалгуур:**

Аудитын явцад олж цуглуулсан баримт, мэдээлэл, судалгаанд олон талын дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад аудитын багт цаг хугацаа давчуу байснаас шалтгаалж зарим дүн шинжилгээг гүйцэтгэх боломжгүй байлаа.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгон авч үзлээ.

- ✚ Монгол Улсын Үндсэн хууль
- ✚ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- ✚ Чикагогийн конвенци
- ✚ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
- ✚ Иргэний нисэхийн тухай хууль
- ✚ Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль
- ✚ Улсын нисэхийн тухай хууль
- ✚ Төрийн албаны тухай хууль
- ✚ Хөдөлмөрийн тухай хууль
- ✚ Төсвийн тухай хууль
- ✚ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ✚ Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”
- ✚ Улсын Их Хурлын 2015 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- ✚ Монгол Улсын Их хурлын 2016 оны 47 дугаар тогтоол
- ✚ Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 57 дугаар тушаалаар баталсан “Байгууллага хоорондын гэрээ байгуулах журам”
- ✚ Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 258 дугаар тогтоолоор баталсан “Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрэм”
- ✚ Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоол “Суудлын автомашины талаар авах арга хэмжээний тухай”
- ✚ Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Дунд хугацааны стратеги батлах тухай”
- ✚ Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 38 дугаар тушаалаар баталсан “Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”
- ✚ Зам, тээврийн сайдын 2016 оны 94 дүгээр тушаалаар баталсан “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр”
- ✚ Холбогдох бусад хууль эрх зүйн актууд

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням, аудитын менежер З.Ариунзаяа нар удирдаж, Чанарын баталгаажуулалтын албаны ахлах аудитор И.Туяа, Гүйцэтгэлийн аудитын газрын аудитор М.Наранжаргал, Стратегийн удирдлагын газрын шинжээч М.Доржханд, гэрээт ажилтан М.Пүрэвмаа нар гүйцэтгэв.

Аудитын хугацаа:

Аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хүртэл аудитын 5 үе шатны ажилбараар ажлын 51 хоногт багтаан хэрэгжүүлэв.



ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ИНЕГ нь Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон эрхийн дагуу, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн хувьд төрөөс Иргэний нисэхийн талаар зайлшгүй хэрэгжүүлэх чиг үүрэг, үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ✚ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Иргэний нисэхийн салбарыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хангах
- ✚ Иргэний нисэхийн талаарх Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллах
- ✚ Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт нислэг, техникийн хэрэг тохиолдсон нөхцөлд шалгалтын ажлын хэсэгт орж ажиллах
- ✚ Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээ олгох
- ✚ Агаарын хөлгүүдэд аюулгүй байдлын шалгалт хийх
- ✚ Агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлэх
- ✚ Агаарын хөлгийн нислэгт холбоо навигацийн хангалт үйлчилгээ үзүүлэх
- ✚ Нисэх буудлын газрын тусгай үйлчилгээ үзүүлэх
- ✚ Иргэний нисэхийн салбарт нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангасан үйлчилгээ үзүүлэх
- ✚ Нисэх буудлын болон агаарын навигацийн үйлчилгээний үнэлгээг олон улсад дагаж мөрдөж байгаа жишигт нийцүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээний үнэлгээг тогтоох, батлах
- ✚ Мэргэжлийн туслалцаа үзүүлэх, мэргэжлийн сургалтыг зохион байгуулах
- ✚ Төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх
- ✚ Иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох
- ✚ Нисэхийн мэргэжлийн ажилтнуудаас шалгалт авах, мэргэжлийн үнэмлэх олгох
- ✚ Агаарын тээврийн байгууллагууд, нисэх буудлууд, нисэхийн аюулгүй байдлыг хангах байгууллага, агаарын навигацид холбогдолтой үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих
- ✚ Иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, зөвлөмж, боловсруулах, хэрэгжилтийг хангах

Тус салбарын эрхэм зорилго нь “Иргэний нисэхийн салбарт аюулгүй, үр ашигтай, тогтвортой үйлчилгээ үзүүлэх”-д оршсон байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратегийг дараах байдлаар тодорхойлжээ.

ИНЕГ-ын стратегийн удирдлага, хяналт, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр буюу үйлчлүүлэгч нь Иргэний нисэхийн багц дүрмийн дагуу гэрчилгээжих агаарын тээвэрлэгч нисэх компани, иргэний нисэхийн үйлчилгээ эрхлэгч, сургалт, тээвэр зууч болон бусад байгууллагууд, мэргэжлийн үнэмлэх эзэмшигчид, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ авагч гадаад, дотоодын агаарын тээврийн нисэх компани, агаарын хөлгүүд, нисэх буудлаар үйлчлүүлэгч байгууллага, зорчигчид байна.


Энэхүү хэрэгцээний эх үүсвэрийг чиг үүргийн дагуу ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтонд нарийвчлан тусган хэрэгжүүлж байна.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн төвөгтэй харилцааг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохицуулахад чиглэжээ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тушаалаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц батлагдсан ба нийт 2430 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.




Бүдүүвч 1: ИНЕГ-ын зохион байгуулалтын бүтэц



Эх сурвалж: ЗТХСайдын 2017 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тушаал

Иргэний нисэхийн ерөнхий газрын нийт орлого 2007 оноос хойш 4.6 дахин, улсын төсөвт төвлөрүүлж буй навигацийн орлого 4.8 дахин тус тус өссөн ба 2007 онд 62,160.5 сая төгрөгийн орлого олсноос 30,032.4 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлж байжээ.

Дүрслэл 1: ИНЕГ-ын сүүлийн 10 жилийн байдлаарх нийт орлого, төсөвт төвлөрүүлсэн навигацийн орлого, нийт орлогын дүнд эзлэх хувь



Дээрх дүрслэлээс үзэхэд 2016 онд 243,692.7 сая төгрөгийн орлого олсноос 115,844.4 сая төгрөгийг, 2017 онд 289,929.1 сая төгрөгийн орлого олсноос 147,604.9 сая төгрөгийн навигацийн орлогыг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн байна.



БҮЛЭГ 1

ИНЕГ-ын 2016-2017 оны мөнгөн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт үр ашиггүй байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн тогтолцоо оновчтой бус байна.

1.1 ИНЕГ нь Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын 2005 оны 10 дугаар сарын 21-ний өдөр бүртгэсэн 000125468 дугаартай аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй байгаа ба төрийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болохыг гэрчилж байна.

1.2 Улсын Их Хурлын 2012 оны 14 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 6 дугаар тогтоолоор ИНЕГ-ыг Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг гэж заажээ.

1.3 Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д: “Агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэсний дагуу агентлагийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байна.

1.4 Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-д “Агаарын навигацийн төлбөртэй үйлчилгээтэй холбогдох асуудлыг эрхлэн шийдэх” гэсний дагуу орлогын эх үүсвэр нь агаарын тээвэрлэгчдийн компаниудын өнгөрөлт, буулт, хөөрөлтийн болон зорчигч үйлчилгээний орлого, бусад орлогуудаас бүрдэж байна.

1.5 Дээрх өөрийн орлогоос үйлдвэрлэлийн албадын зардлыг санхүүжүүлж ирсэн байна.

Хүснэгт 1: ИНЕГ-ын 2016, 2017 оны орлого, зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл

сая төгрөг

Үзүүлэлт	2016 он		төл. гүйц.	2017 он		төл. гүйц.
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Орлого	189,059.8	243,692.7	28.9	258,119.2	289,929.1	12.3
Өнгөрөлтийн орлого	161,619.7	192,541.1	19.1	231,083.8	242,833.9	5.1
Буулт, хөөрөлтийн орлого	8,978.9	11,060.6	23.2	8,211.0	11,750.1	43.1
Зорчигч үйлчилгээний орлого	8,803.9	9,490.7	7.8	8,975.0	11,241.1	25.3
Бусад орлого	9,657.4	22,193.1	129.8	9,849.4	19,912.1	102.2
УТ-ийн санхүүжилт	-	8,407.1	-	-	4,189.1	-
ҮХ данснаас хассан олз	-	-	-	-	2.8	-
Зарлага	192,125.4	230,362.8	34.4	261,283.5	268,688.4	0.4
Улсын төсөвт төвлөрүүлсэн навигацийн орлого	103,087.1	115,844.4	12.4	144,921.0	147,604.9	1.9
Үйлдвэрлэлийн зардалд	85,972.7	104,844.7	22.0	113,198.2	112,262.8	(0.8)
Агентлагийн зардалд	3,065.6	3,065.6	-	3,164.3	3,142.3	(0.7)
Орлогын албан татварт	-	6,608.1	-	-	5,678.4	-
Ашиг	-	13,329.90	-	-	21,240.70	-

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

1.6 2016 онд нийт 243,692.7 сая төгрөгийн орлого олсноос, улсын төсөвт 115,844.4 сая төгрөг төвлөрүүлсэн, үйлдвэрлэлийн зардалд 104,844.7 сая, агентлагийн зардалд 3,065.6 сая, орлогын албан татварт 6,608.1 сая, нийт 230,362.8 сая төгрөгийг зарцуулж, 13,329.9 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

1.7 2017 онд нийт 289,929.1 сая төгрөгийн орлого олсноос, улсын төсөвт 147,604.9 сая төгрөг төвлөрүүлсэн, үйлдвэрлэлийн зардалд 112,262.8 сая,



агентлагийн зардалд 3,142.3 сая, орлогын албан татварт 5,678.4 сая, нийт 268,688.4 сая төгрөгийг зарцуулж, 21,240.7 сая төгрөгийн ашигтай гарчээ.

1.8 Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг гэсний дагуу ИНЕГ нь Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалыг баримтлан санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаж байна.

1.9 Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7-д: “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Компанийн тухай хуульд заасан журмын дагуу жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргана” гэсний дагуу Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалыг баримтлан санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаж байна.

1.10 Зам, тээврийн хөгжлийн сайдын 2015 оны 02/3122, 2016 оны 01/2972 дугаартай албан бичгүүдийн дагуу Агентлагийн 2016 оны төсөвт зардал 3,065.6 сая төгрөгөөр, 2017 оны төсөвт зардал 3,164.3 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна.

1.11 Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2016 оны 126/413 дугаартай хамтарсан тушаалаар Үйлдвэрлэлийн албадын 2016 оны төсөвт зардал 85,972.7 сая төгрөгөөр, Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын 2017 оны 266/385 дугаартай хамтарсан тушаалаар 2017 онд 113,198.2 сая төгрөгөөр тус тус батлагджээ.

1.12 ИНЕГ-ын бүтэц, зохион байгуулалт болон санхүүжилтийн хэлбэр оновчтой бус байгаагаас шалтгаалж дараах хүндрэл бэрхшээлүүд гарч байна. Үүнд:

- ✚ ИНЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг 2 өөр хэлбэрээр /СС-ын 2015 оны 315 дугаар тушаал, СС-ын 2017 оны 361 дүгээр тушаал/ гаргахад хүргэсэн байна.
- ✚ Төсвийн тухай хуулийн дагуу навигацийн орлогоос улсын төсөвт 2016 онд 115,844.4 сая, 2017 онд 147,604.9 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.
- ✚ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу орлогын албан татварт 2016 онд 6,608.1 сая, 2017 онд 5,678.4 сая төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн.
- ✚ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2017 оны А-1/102 дугаар тогтоолын дагуу Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2015-2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс ногдол ашиг 5,461.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж байна.

1.13 Дээрхээс үзэхэд Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.5-д “Иргэний нисэхийн үйлчилгээний орлогыг хууль тогтоомжийн хүрээнд нисэхийн аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагаанд зориулан захиран зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, нөгөө талаас навигацийн орлогын тодорхой хэсгийг иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд зарцуулаагүй байна. Энэ нь аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал алдагдсанаас ирээдүйд их эрсдэл үүсэх магадлал өндөр тул цаашид урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

“Чингис хаан” ОУНБ-ын Капитал банкнаас улсын төсвийн дансанд шилжүүлсэн навигацийн орлого 63 хоногоор саатуулагджээ.

1.14 Капитал банкаар дамжуулан гүйлгээ хийгдсэн навигацийн орлогын хувьд, “Чингис хаан” ОУНБ-ын капитал банкны 2061002679 дугаартай данснаас 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр навигацийн орлого 2,000.0 сая төгрөгийг Сангийн яамны Төрийн сангийн 100900000707 дугаартай данс руу шилжүүлсэн боловч 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр “Чингис хаан” ОУНБ-ын санхүү, Сангийн яамны Төрийн сантай тооцоо нийлэхэд дээрх орлого дансанд ороогүй Капитал банкинд саатуулагдсан байна.



1.15 Дээрх саатуулагдсан орлогын талаар Капитал банк руу, “Чингис хаан” ОУНБ-ын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 07/6/2002, 12 дугаар сарын 28-ны өдрийн 07/6/2007 дугаартай албан бичгүүдийг хүргүүлж, дээрх орлогыг буцаан дансанд байршуулах ба ашигласан хугацааны хүүг тооцож шилжүүлэхийг шаардсан байна.

1.16 Үүний дагуу Капитал банк 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 2,000.0 сая төгрөгийг “Чингис хаан” ОУНБ-ын 2061002679 дугаартай дансанд буцаан байршуулсан ба түүнд ногдох хүү 17.5 сая төгрөгийг 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр “Чингис хаан” ОУНБ-ын 2061002679 дугаартай дансанд шилжүүлсэн байна.

Хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж ажиллах шаардлагатай байна.

1.17 Мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг 2016-2017 онд 9 арилжааны банкны төгрөгийн 40, валютын 12 харилцах дансаар хийжээ. Тухайлбал, Төрийн санд 6, Худалдаа хөгжлийн банкинд 6, Голомт банкинд 9, Төрийн банкинд 11, Улаанбаатар хотын банкинд 2, ХААН банкинд 5, Капитрон банкинд 4, Капитал банкинд 3, Богд банкинд 2, Чингис хаан банкинд 2, Хас банкинд 2 харилцах данстай байна.

1.18 Дээрх дансдын ажил гүйлгээнд ЗГ-ын 374 дүгээр тогтоолоор 2015 оны 09 дүгээр сарын 14-ний өдрөөс 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Нямдаваа, МУЗГ-ын 77 дугаар тогтоолоор 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Бямбасүрэн, МУЗГ-ын 134 дүгээр тогтоолоор 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс одоог хүртэл ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн нар нэгдүгээр гарын үсгийг, ИНЕГ-ын даргын 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн Б/67 дугаар тушаалаар 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс одоог хүртэл Ерөнхий нягтлан бодогч Н.Наранцэцэг хоёрдугаар гарын үсгийг зурж ирсэн байна.

1.19 Аудитын хугацаанд 2016-2017 оны мөнгөн хөрөнгийн нийт 260 боть материал, өмнөх 2012-2015 оны материалаас түүвэрчилэн шалгаж, хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдалтай танилцахад ИНЕГ-ын зарим албан тушаалтнууд албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэм буруутай үйлдлээрээ байгууллагад 5,999.0 сая, улсад 6,034.8 сая төгрөгийн хохирол учруулсан байна. /Хавсралт № 6-ын 1-5 дах жагсаалтын дүн/

1.20 Харин Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.2-д: “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана” гэсний дагуу шүүхийн шийдвэрээр ИНЕГ-ын харилцах данснаас шууд суутган тооцож хувь хүн болон аж ахуйн нэгжийн хохирлыг барагдуулсан боловч буруутай албан тушаалтнуудад хариуцлагын арга хэмжээ авагдаагүй байна.

1.21 Иймд Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д: “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэсний дагуу албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагаанаас байгууллага болон улсад 12,033.8 сая төгрөгийн хохирол



учруулсан байдлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

1.22 2016-2017 онуудад нийт 7,505.3 сая төгрөгийн төсөвт зардлын ашиглалт үр нөлөө багатай байна. /Хавсралт №6-ын 6-18, 21-24, 28 дэх жагсаалтын дүн/ Тухайлбал:

- + Тэмдэглэлт ойн арга хэмжээнд 320.5 сая,
- + Улаанбаатар хотноо 2016 онд АСЕМ-ийн дээд түвшний 11 дэх уулзалтыг зохион байгуулахад оролцсон ажилтнуудын урамшуулалт цалин, бусад арга хэмжээнд 203.7 сая,
- + ИНЕГ-т хууль эрх зүйн газар ажиллаж байгаад 2016 онд бүтцийн өөрчлөлтөөр татан буугдаж, 2017 онд хуулийн мэргэжилтэн ажиллаж байгаа боловч 2014-2016 онуудад гадны хувийн байгууллагаас хууль, эрх зүйн үйлчилгээ авсан хөлсөнд 245.1 сая,
- + “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал”-ын барилга, байгууламж ашиглалтад орж, үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байхад түүнтэй холбоотой ашиглалтын болон урсгал зардалд 2017 онд 5,886.0 сая,
- + Олон улсын шинэ нисэх буудлын халаалтын зардал төлөгдөөгүй төлбөр, түүний алдангийг шүүхийн шийдвэрээр гаргуулсан зардалд 247.8 сая
- + “Гүрэн” дээд сургуульд сургалтын төлбөрт 512.0 сая,
- + “Орон сууцны хөнгөлөлт олгох журам”-ийн шалгуур үзүүлэлт хангаагүй 1 ажилтанд, мөн давхардуулан 1 ажилтанд орон сууцны хөнгөлөлт олгосон 42.0 сая,
- + Ховд аймгийн Ховд нисэх буудлын аэродромын урсгал засварт төлөвлөгөөнөөс гадуур зардал гаргасан 48.2 сая төгрөг.

1.23 Өөрийн чиг үүрэгт хамааралгүй зардлыг 1,706.5 сая төгрөгөөр санхүүжүүлжээ.

- + Хан-Уул дүүргийн 10,16 дугаар хороодын “Ахмад настан, хүүхэд багачуудад зориулсан амралт, чийрэгжүүлэлтийн талбай” байгуулахад 48.9 сая,
- + Хан-Уул дүүргийн 9, 13 дугаар хороодын “Хүүхдийн тоглоомын талбай” байгуулахад 48.9 сая,
- + Зам, тээврийн хөгжлийн яамны зарим ажилтнуудын гадаад, дотоод томилолт болон суудлын автомашин ашигласан зардалд 2016-2017 онд 358.1 сая,
- + ЗТХЯ-ны 3 ажилтанд орон сууцны хөнгөлөлт олгосон 35.8 сая,
- + ИНЕГ-ын бүтэц, орон тоонд тусгагдаагүй албаны үйл ажиллагаанд 1,214.8 сая төгрөг.

1.24 Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д: “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д: “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д: “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.25 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр 2017 оны 07 дугаар сарын 27-ны өдөр Сэргээн засах амралтын газарт гэрийн тавилга 28.8 сая төгрөгөөр, 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр “Моннис Моторс” ХХК-аас “Ниссан теана” маркийн суудлын автомашин 3 ширхгийг 170.7 сая төгрөгөөр, 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр “Ниссан патрул жийп” маркийн суудлын автомашин 2 ширхгийг 376.2 сая төгрөгөөр тус тус худалдан авчээ.

1.26 Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн



З-д: “Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр олж авна” гэсэн заалтуудыг баримталж ажиллаагүйтэй холбоотой байна.

Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагыг зохих ёсоор бүртгэж, тайлагнаж иржээ.

1.27 Мөнгөн хөрөнгийн тайланг СТОУС 7-ын дагуу тухайн хугацааны туршид гарсан хөрөнгө оруулалтын, санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааны ажил гүйлгээг тайлагнасан байна.

1.28 Мөнгөн орлого, зарлагын гүйлгээг анхан шатны баримтаас мөнгөн орлого, зарлагын журнал хөтөлж, ерөнхий дэвтэрт бичилтүүдийг хийж, тайлант хугацаанд мөнгөн хөрөнгийн данс тус бүр дээр гарсан гүйлгээ нэг бүрийг анхан шатны баримттай тулган шалгаж, холбогдох дансдад үнэн зөв бичигдсэн эсэхийг хянаж үзсэний эцэст мөнгөн хөрөнгийн дансдын тайланг гаргаж, тайлант хугацааны эцэст мөнгөн хөрөнгийн дансдын эцсийн үлдэгдэл болон гүйлгээний дүнг банкны хуулга, бэлэн мөнгөний үлдэгдлийн тооллоготой тулган шалгаж баталгаажуулжээ.

1.29 Мөнгөний орлого, зарлагын гол ажил гүйлгээнүүдэд мөрдөх горим нь орлогын нягтлан бодогчийн тодорхойлж, нэхэмжилсэн орлого харилцах дансанд орсон үед мөнгөн хөрөнгийн нягтлан бодогч дансны авлагын тооцоог хааж, мөнгөний орлогыг бүртгэж байна. Харин төвийн салбарууд болон орон нутгийн нисэх буудлуудын санхүүжилт нь үйл ажиллагааны бус мөнгөн орлогод хамаарч байна.

1.30 Орон нутгийн нисэх буудлуудын санхүүжилтийг харилцах дансанд төвлөрүүлэн түгээж байгаа ба уг санхүүжилт нь хөрөнгө оруулалтаас бусад зардалд зориулагдсан ба төвийн салбаруудын хөрөнгө оруулалт, гадаад арга хэмжээ, гадаад томилолт, сургалтын зардлыг зарцуулж, холбогдох салбар нэгжүүдэд хувиарлан бүртгэж байна.

**БҮЛЭГ 2****Агаарын тээврийг хөгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний үр нөлөө хангалтгүй байна.*****Агаарын тээвэрлэгч компаниас хүсэлт гаргаагүйгээс нислэгт тэнцэх чадварын гэрчилгээг хүчингүй болгоогүй байна.***

2.1 Монгол Улсын агаарын зайд нийт 62 агаарын зам тогтоогдсоноос 52 нь уламжлалт, 10 нь үзүүлэлтэд тулгуурласан агаарын замууд байгаа ба БНХАУ-тай 6, ОХУ-тай 9 агаарын хаалгаар холбогдож байна.

2.2 ИНЕГ-аас ИНД-121, 135, 137, 149, 129¹-ийн дагуу иргэний агаарын тээврийн үйлчилгээ явуулах дотоодын 10, гадаадын 8 авиа компанид агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлтийг олгосон байна. /хавсралт №1, 2/

2.3 Мөн ИНД-171, 172, 173, 175-ын дагуу Агаарын навигацийн үйлчилгээ үзүүлэгч Иргэний нисэхийн техник хангалт, үйлчилгээний алба, Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба, Нислэгийн журам, үйлчилгээ, шалгалтын нислэг, зураглалын алба, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албыг тус тус гэрчилгээжүүлжээ. /хавсралт №3/

2.4 2003-2017 онд ИНД-21-ын дагуу дотоодын 9 авиа компанийн 16 агаарын хөлөг² нислэгт тэнцэх чадварын гэрчилгээжүүлэлт хийгджээ. /хавсралт №4/

2.5 Нийт 5 агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хүчинтэй хугацаа өмнөх онуудад дуусгавар болсныг тухайн агаарын тээвэрлэгч компаниас */агаарын хөлгийн техник үйлчилгээ, их засварын ажлаа гүйцэтгээгүй шалтгаанаар/* гэрчилгээг сунгуулах хүсэлт гаргаагүй, ИНЕГ-аас ИНД-21.179/е/-т *“...агаарын хөлөгт ямар нэгэн эвдрэл гарсан тохиолдолд, тухайн агаарын хөлгийг нислэгт тэнцэх чадвартай эсэхийг энэ дүрмийн хавсралт В-д тодорхойлсон загварын нислэгт тэнцэх чадварын стандартуудын дагуу тогтоож шийдвэрлэнэ...”* гэсний дагуу шийдвэр гаргаагүй зэргээс нислэгт тэнцэх чадварын гэрчилгээг хүчингүй болгоогүй байна. Үүнд:

Хүснэгт 2: Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ сунгагдаагүй судалгаа

№	Агаарын			НТЧ-ын дууссан хугацаа
	тээвэрлэгч байгууллага	хөлгийн маяг	хөлгийн бүртгэлийн дугаар	
1	“Аэромонголиа” ХХК	Fokker 50	JU 8250	2016.11.24
2	“Хүннү эйр” ХХК	Fokker 50	JU 8882	2017.06.06
3	“А жет авиэйшн” ХХК	EC145 helicopter	JU 5499	2015.11.12
4	“Томас Эйр” ХХК	Maule M-7235C	JU 1919	2017.06.13
5	“Хүннү эйр сервис” ХХК	Ан-2 с/х	JU 1046	2013.12.05

2.6 Энэ нь ИНД-21.179/б/-т *“...агаарын хөлгийн стандарт, эсхүл хязгаарлагдмал ангиллын нислэгт тэнцэх чадварын гэрчилгээг /агаарын хөлгийг гадаад улсад бүртгүүлэх, агаарын хөлөг, түүний хөдөлгүүр, сэнсэнд олгосон маягийн гэрчилгээ эсхүл маягийн хүлээн зөвшөөрөх гэрчилгээ нь хүчингүй болсон/ хүчингүй болгоно”* гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

2.7 Харин Нислэгийн цаг уурын төвийг цаг уурын ажиглалт хийх, цаг уурын нөхцөлд хяналт тавих, мэдээ солилцох, зөвлөмж өгөх, урьдчилан мэдээлэл, уур

¹ (а) МУ-д арилжааны зорилгоор агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах гадаадын агаарын тээвэрлэгч нь, дараалсан 28 хоногийн дотор 2-оос дээш удаа, эсхүл дараалсан 365 хоногийн дотор 8-аас дээш удаа хөөрөлт, буулт үйлдэх бол

² стандарт ангилал 14, хязгаарлагдмал ангилал 2



амьсгалын мэдээллээр хангах, хэрэглэгчдэд хандсан үйлчилгээ үзүүлэх төрлөөр дахин гэрчилгээжүүлж, үйл ажиллагааны тодорхойлолтод 18 аймаг, 3 хотын УЦУОШГазар, Тосонцэнгэл, Овоот, Ханбумбат, Таван толгойн нисэх буудал нислэгийн цаг уурын үйлчилгээг хамруулахаар заажээ.

2.8 2016-2017 онд агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч дотоодын 7, гадаадын 3, ачаа тээврийн 1 авиа компанид үзлэг шалгалт хийж, байцаагчийн дүгнэлтээр илэрсэн нийт зөрчил, шаардлагыг ангилсан судалгаагүй³, нийтлэг болон давтан гарч буй зөрчилд дүн шинжилгээ хийдэггүй байна.

Ховд нисэх буудлыг дүрмийн шаардлага хангаагүй байхад олон улсын 4С ангиллын аэродромын гэрчилгээжүүлэлт олгосон байна.

2.9 ИНЕГ-аас ИНД-139-ын дагуу 2011-2014 оны хооронд 26 байгууллага /давхардсан тоогоор/ аэродромын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасны дагуу гэрчилгээ олгосноос “Чингис хаан” ОУНБ, Арвайхээр, Баянхонгор, Алтай, Мөрөн, Улаангом, Дэглий цагаан, Ховд, Өлгий, Доной, Овоот, Гурвансайхан, Ханбумбат нисэх буудлууд гэрчилгээтэй, Баруун-урт, Мандалговь, Булган, Тосонцэнгэл, Ховд, Булган нисэх буудлууд түр зөвшөөрлийн гэрчилгээтэй байна.

2.10 ИНЕГ-ын даргын 2014 оны А/671 дугаартай тушаалын хавсралтаар аэродромуудын гэрчилгээжүүлэлтийн ангиллыг шинэчлэхдээ Ховд аэродромын хөөрч, буух зурвасын чиглэл, хучилт нь асфальт, хөөрч буух зурвасын хэмжээ 2850х49 метр, аэродромын ангилал II гэж баталжээ.

2.11 Гэвч одоо 2850х35 метр байгаа ба өөрөөр хэлбэл хатуу хучилттай зурваст хүчитгэл хийгээгүй байхад 4С ангиллын аэродром болгосон, 3С ангиллын агаарын хөлгүүдээр үйл ажиллагаа явагдаж байгаа учраас аэродромын гэрчилгээг бодит нөхцөл, иргэний нисэхийн дүрмийн шаардлагад нийцүүлэн зэрэглэл, ангиллыг тогтоох нь зүйтэй байна.

2.12 Тухайлбал, Ховд нисэх буудлын аэродромын гэрчилгээг ИНД-139 шаардлагыг бүрэн хангаагүй байхад 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 139 дугаартай олон улсын 4С хяналтын кодтой, II ангиллаар /НААХЗГ-ын аэродром, агаарын навигацийн хэлтсийн дарга Х.Батсайхан/ олгож, гэрчилгээний хүчинтэй хугацааг 2 удаа буюу 2016.10.01, 2018.10.01 хүртэл /НААХЗГ-ын ААНХХ-ийн дарга С.Ерханат/ сунгасан байна.

“МИАТ” ХК-ийн В-737-800 маягийн агаарын хөлгийн нисэх баг Ховдын аэродромын хөөрч буух зурвасын хөвөөг дайрч эвдрэл үүсгэжээ.


2.13 Ховд аймгийн Ховд нисэх буудлаас 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдөр “МИАТ” ХК-ийн В-737-800, EI-CXV агаарын хөлөг хөөрөлтийн үед чиг алдан зурвасаас гарсан ноцтой зөрчилд ЗТХЯамны НТОЗШША-аас 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр гаргасан шалгалтын тайлантай танилцахад Ховд нисэх буудлын аэродромыг гэрчилгээжүүлсэн нь шаардлага⁴ хангахгүй байна.

³ Аудитаар зөрчил, шаардлагыг ангилан судалгаа хийж ирүүлсэн.

⁴ олон улсын 4С, II ангиллаар гэрчилгээг олгосон




2.14 “МИАТ” ХК-ийн В-737-800 маягийн агаарын хөлгийн нисэх баг хөөрөлт үйлдэх явцад чиг алдсаны улмаас хөөрч буух зурвасын хөвөөг дайрч гэмтээж тус аэродромд 48.2 сая төгрөгийн урсгал засвар хийгдсэн байна.



Зураг1. Хөөрч буух зурвас баруун ирмэгийн гэмтэл

Эх сурвалж: ЗТХЯамны Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Ноцтой зөрчлийг шинжлэн шалгасан тайлан”



Зураг 2. Зурвасын баруун гар тал уруу гарсан байдал

Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн болон агаарын хөлгийн нэгдсэн мэдээлэл бүртгэлгүй байна.

2.15 Монгол Улсын иргэний агаарын хөлгийн бүртгэлд 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 35 агаарын хөлөг бүртгэлтэйгээс “МИАТ” ХК-ий эзэмшиж байгаа 3 агаарын хөлөг Бүгд Найрамдах Ирланд улсад, 32 агаарын хөлөг Монгол Улсад тус тус бүртгэлтэй байна.

2.16 Гэтэл иргэний агаарын тээврийн агаарын хөлөг болон гэрчилгээ эзэмшигчийн мэдээллийг Windows үйлдлийн системийн Excel-ээр хөтөлдөг.

2.17 Монгол Улсын иргэний агаарын хөлгийн нэгдсэн мэдээлэл бүртгэлийн програмгүй байгаа ба цаашид агаарын тээвэрлэгчийн болон агаарын хөлгийн, бусад гэрчилгээ эзэмшигчийн мэдээллийг агуулсан нэгдсэн бүртгэлийн сантай болох нь зүйтэй.

2008 онд коммерийн нисгэгчийн үнэмлэхийг хуурамчаар олгосон байна.

2.18 ИНЕГ нь ИНД-61-ийн дагуу 2007-2017 онуудад агаарын тээвэрлэгчийн нисгэгч 94, коммерийн нисгэгч⁵ 107, зөөгдөж байгаа 18 нийт 210 нисгэгчийн үнэмлэх гэрчилгээжүүлэлтийг олгосон байна. /хавсралт №5/

2.19 Тухайлбал, НТОЗШША-ын шалгалтын тайланд⁶ “МИАТ” ХК-ийн В737-800 маягийн EI-CSG агаарын хөлгийн нисэх баг БНХАУ-ын Бээжин нисэх буудалд буухдаа гаргасан ноцтой зөрчилд Э.Ганхүүгийн талаар дараах зүйлийг бичжээ.

“МИАТ” ХК-ийн 2 дугаар нисгэгч Э.Ганхүү нь Канадын Калгари хотын Вингс нисэхийн академийг төгссөн гэх боловч тус сургуулийг төгссөнийг гэрчлэх баримт байхгүй, Канадын тээврийн газраас ямар нэгэн нисгэгчийн үнэмлэх аваагүй байна,

⁵ Хоёрдугаар нисгэгч

⁶ “Агаарын хөлгийн багийн гишүүд хүчилтөрөгч хэрэглэж “Emergency descent”



- “МИАТ” ХК нисгэгчийн дадлага туршлагад тавигдах шаардлагыг хангаагүй Э.Ганхүүг 2009 оны 1 сард Б737-800 агаарын хөлгийн шилжин сургалтад хамруулан ИНД-121.79-ийн шаардлагыг зөрчсөн,
- “МИАТ” ХК-ийн нислэгийн үйл ажиллагаа эрхэлсэн дэд дарга З.Энхбаяр нисгэгч Э.Ганхүүг ИНД-121.79/а/1/ тодорхой заалтын шаардлагаас чөлөөлөх өргөдөл гаргасан байхад ИНЕГ-ын тэргүүн дэд дарга /П.Мөнхжаргал/ нь Э.Ганхүүг ИНД-121.79-ийн бүх заалтын шаардлагаас чөлөөлсөн шийдвэр гаргаж, Б737-800 агаарын хөлгөөр үйлдвэрлэлийн дадлагын нислэг хийхийг зөвшөөрсөн байна... гэж бичсэн байна.

2.20 ИНЕГ-аас 2008 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Энх-Амгалан овогтой Ганхүүд СА-0126 дугаартай Коммерийн нисгэгчийн үнэмлэх олгожээ.

2.21 Харин үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтсээс ирүүлсэн Э.Ганхүүгийн хувийн хэрэгт буй баримтаар Канад улсын Calgary Flying Club иргэний нисэхийн сургалтын байгууллагад Э.Ганхүү нь нисгэгч мэргэжлээр 2013 онд суралцаж үнэмлэх авсан, Канад улсын тээврийн газраас 2014 онд коммерийн нисгэгч /CPL/ үнэмлэх олгосон зэргийг гэрчилж байна.

Ази, Европын чиглэлд дотоодын 3 агаарын тээврийн компани 24 чиглэлд нислэг үйлдсэн байна.

2.22 ИНД-300-ын дагуу МУЗГ болон Гадаад улсын ЗГ-ын хоорондын Агаарын харилцааны хэлэлцээр, санамж бичгийн дагуу Ази, Европын 14 орны 24 чиглэлд агаарын тээвэрлэгч дотоодын 3, гадаадын 7 компани байгаагаас “МИАТ” ХК нь 6 улсын 11 чиглэл, “Аэромонголиа” ХХК 2 улсын 5 чиглэл, “Хүннү Эйр” ХХК 3 улсын 6 чиглэлд, “Эйр Чайна”, “Тяньжин Эйрлайнз”, “Скат”, “Эйр Астана”, “Бек Эйр”, “Аэрофлот”, “Ир Аэро” агаарын тээврийн томилгоотой ажиллаж байна.

2.23 Мөн 2017 онд “МИАТ” ХК нь Бангкок, Бусан хотуудын чиглэлд, “Хүннү Эйр” ХХК-нь Улаан-Үүд хотын чиглэлд шинээр нислэг үйлдэж эхэлсэн байна.

2.21 ИНД-337-ын дагуу агаараар ачаа тээвэр зуучлалын үйлчилгээ эрхлэхээр дотоодын “МАТ” ХХК, “Туушин” ХХК, “Мон Аэр Тур” ХХК, “Ашли Транс” ХХК, “Ди Эйч Эл” ХХК, “Эйр Пасифик” ХХК гэрчилгээ эзэмшиж байна.

Иргэний нисэхэд ашиглах агаарын зайн бодлогын баримт бичгийг батлуулах шаардлагатай байна.

2.23 Агаарын навигацийн үйлчилгээнд нислэгийн хөдөлгөөн удирдлага, техник хангалт, нисэхийн мэдээллийн үйлчилгээ, нислэгийн журам боловсруулалт, нислэгийн оношлогоо хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагааг хамруулан явуулж байна.

2.24 ИНЕГ-ын даргын 2017 оны А/605 дугаар тушаалаар “Агаарын навигаци-2024” стратеги төлөвлөгөөний дагуу гаргасан үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2017 оны хувьд нийт 18 чиглэлийн ажлыг тусгажээ.

2.25 Тухайлбал, агаарын менежментийн талаар хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2017 онд нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүд хооронд өгөгдөл солилцох, 2017-2018 онд ИНД-ийг шинэчлэх, хоёрдогч радиолокаторын төхөөрөмж нь эдийн засгийн ач холбогдол бага, ашиглалтын зардал хэт өндөр байснаас шалтгаалж ADS-B системийг ашиглахаар байна.

2.26 Улс орнууд нь иргэний нисэхийн салбарын аюулгүй ажиллагаа, үр ашгийг хангах зорилгын хүрээнд өөр өөрсдийн агаарын зайд А, В, С, D, E, F, G гэсэн 7-н



ангиллаас аль тохиромжтой ангиллуудыг сонгож ашиглах шаардлагыг ОУИНБ-ын Чикагогийн конвенцийн хавсралт 11-т тусгадаг байна.

2.27 ИНЕГ нь ИНД-71-ийн дагуу Монгол Улсын агаарын зайг үндсэн шаардлагын хүрээнд А, В, С, D, E, F, G гэсэн 7-н ангилалд хуваан тогтоохоор заасан ч одоогоор агаарын зайг А, С, D, G 4-н ангиллаар ашиглаж байгаа ба орон нутгийн нисэх буудлуудын нислэгийн ачаалал бага, олон ижил төрлийн ангиллыг хэрэглэх нь агаарын зайд үйл ажиллагаа эрхлэгчдэд хүндрэл үүсгэх, Монгол Улсын хэмжээнд түр ашиглахаар тогтоох агаарын зайн хэрэгцээ гараагүй зэргийг харгалзан В, Е, F ангиллын агаарын зайг ашиглах шаардлагагүй гэж үзсэн байна.

2.28 Монгол Улсын агаарын зайн ангиллыг сегментээр нь авч үзэхэд А ангилалд Монгол Улсын далайн түвшнээс дээш авсан 6150 м-ийн өндрөөс дээш агаарын зай, С ангилалд 10 нисэх буудал, D ангилалд 5 нисэх буудал, G ангилалд зарим нисэх буудлуудын агаарын зай ба бусад агаарын зай /түр ашиглагдах нисэх буудлууд/ хамааралтай байна.

2.29 Монгол Улсын агаарын замууд нь 2 навигацийн төхөөрөмж болон солбилцлуудын хооронд чиг шулуун байхаар тогтоогдсон бөгөөд агаарын зайн ангилал, агаарын замуудад бүрэн дүн шинжилгээ хийгээгүй байна.

2.30 Харин ИНЕГ-ын даргын 2010 онд баталсан “Иргэний нисэхэд ашиглах агаарын зайн бодлогын баримт бичиг”-ийг ашиглан 2017 онд орон нутгийн нисэх буудлуудад тогтоогдсон агаарын зайн ангилал, зохион байгуулалт нь одоогийн нөхцөл байдал, агаарын навигацийн бодлого, төлөвлөлтөд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ, судалгааг хийжээ.

2.31 Орон нутгийн 22 нисэх буудлын агаарын зайн ангиллыг одоогийн байгаа С /хяналттай агаарын зай/ ангиллаас D ангилалд 7 нисэх буудал /Ховд, Өлгий, Мөрөн, Гурвансайхан, Ханбумбат, Дэглий цагаан, Чойбалсан/, D ангиллаас G⁷ /хяналтгүй агаарын зай/ ангилалд 4 нисэх буудал /Баянхонгор, Арвайхээр, Доной, Өндөрхаан/ зэрэгт өөрчлөлт оруулахаар тооцож, орон нутгийн нисэх буудлуудын хяналттай агаарын зайн ангилал, босоо, хэвтээ хязгаарын шинэчилсэн төслийг боловсруулсан байна.

2.32 “Иргэний нисэхэд ашиглах агаарын зайн бодлогын баримт бичиг”-ийг Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3⁸, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1⁹ -ын холбогдох заалтуудтай уялдуулан төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах нь зүйтэй байна.

Агаарын зайн ашиглалтыг сайжруулах бодлогын хүрээнд олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо өссөн байна.

2.33 ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүсийн ерөнхий захирлуудын 54 дүгээр хуралдааны үр дүнд Монгол Улс БНХАУ-тай агаарын хаалга шинээр нээх, агаарын зайн ашиглалтийг сайжруулах замаар олон улсын өнгөрөлтийн нислэгийг

⁷“G” ангиллын агаарын зай /Class G airspace (a) Энэ дүрмийн 71.57, 71.101, 71.103, 71.105, 71.107-д зааснаас бусад, дараах хяналтгүй агаарын зайд “G” ангилал тогтооно: 1 /зөвхөн ИХНД-ээр нислэг үйлдэгдэх/; 2 /нисэх багийн хүсэлтээр нислэгийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх./

⁸ Монгол Улсын агаарын зайд иргэний нисэхийн зориулалтаар ашиглах агаарын зам, агаарын хаалгыг тогтоох, олон улсын нислэгийн чиглэлийг нээх, хаах, нисэхэд ашиглах агаарын зайг тогтоох

⁹ Иргэний нисэхэд ашиглах агаарын зайг олон улсын хэм хэмжээ, иргэний нисэхийн үйл ажиллагаанд нийцүүлэн иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.



нэмэгдүүлж, навигацийн үйлчилгээний орлогыг өсгөх, эдийн засгийн үр ашгийг сайжруулах арга замыг судлах талаар үр дүнтэй ажлууд хийгджээ.

2.34 Тухайлбал, агаарын зайн уламжлалт замаас нислэгийн эрчимжилт ихтэй голлох чиглэлүүдэд 7 шулуун агаарын замыг тогтоож шинэчилсэн нь Монгол Улсын агаарын замаар дайран өнгөрөх агаарын тээвэрлэгч авиа компанид эдийн засгийн хувьд хэмнэлтийг бий болгосон, олон улсын өнгөрөлтийн нислэг нэмэгдсэнээр агаарын хөлөгт үзүүлэх навигацийн үйлчилгээний орлого өсөхөд нөлөөлсөн байна.

2.35 Мөн агаарын навигацийн хураамж тооцох аргачлал нь агаарын хөлгийн хөөрөлтийн жинг 6 ангилалд тооцоолдог байсныг нарийвчлан 16 ангилалд хувааж агаарын хөлгийн жинг 25 тонн тутамд 34-96 ам.доллар болгон өсгөж шинэчлэн өөрчилсөнөөр 2017 оны сүүлийн хагаст олон улсын өнгөрөлт, буулт, хөөрөлтийн нислэгийн тоог өмнөх оны мөн үеэс 17.5-31.2 хувиар өссөн байна.

Дүрслэл 2: 2016-2017 оны VII-XII саруудын өнгөрөлтийн нислэгийн харьцуулалт



Дүрслэл 3: 2016-2017 оны VII-XII саруудын олон улсын буулт, хөөрөлтийн харьцуулалт




Баруун хэсгийн агаарын замууд харж удирдах ажиглалтын системгүй байна.

2.36 Монгол Улсын агаарын замаар нэвтрэн өнгөрч байгаа агаарын хөлгийг харж удирдах ажиглалтын хоёрдогч радиолокаторын станцыг 2009 оноос эхлэн 2015 оны хооронд үе шаттайгаар 7 радиолокаторын станцаар агаарын замын 80 орчим хувийг хамарсан бүрхэлтийг бий болгожээ.




2.37 Гэтэл Баруун хэсгийн агаарын замуудын Ховд аймгийн Ховд, Булган сум, Баян-Өлгий аймгийн Өлгий, Завхан аймгийн Ургамал, Улаангом сумдад радиолокаторын байгууламж байхгүй, баруун хил орчимд харж удирдах ажиглалтын системгүй, агаарын замуудын 20 гаруй хувь нь бүрхэлтгүй байгаа ч Монгол Улсын баруун бүсийн агаарын зайд нислэгийн эрчимжилт бага тул нислэг хөдөлгөөн удирдлагын эрчимжилт нь процедур удирдлагаар үйл ажиллагаа явуулах боломжтой гэж үздэг байна.



Зураг 3. Хоёрдогч радиолокаторын бүрхэлтийн зураг

2.38 2012 оноос эхлэн автомат хамааралтай ажиглалтын ADS-B системийг төвийн болон зүүн замуудын дагуу нийт 12 системийг суурилуулж агаарын замын давхар бүрхүүлийг бий болгож, нислэгийн хөдөлгөөн удирдлагад туршилт тохируулгыг хийж байгаа ч одоогоор агаарын хөлгийн зайчлалд ашиглаж эхлээгүй байна.



Зураг 4. ADS-B системийн бүрхэлтийн зураг

2.39 Баруун хэсгийн агаарын замуудад радиолокаторын байгууламж суурилдаагүй, харж удирдах ажиглалтын системгүй байна. Цаашид тухайн агаарын замаар нислэгийн эрчимжилт нэмэгдэх нөхцөлд агаарын хөлөгт навигацийн үйлчилгээг бүрэн үзүүлэхийн тулд автомат хамааралтай ажиглалтын ADS-B системийг зайчлалд ашиглах шаардлага тавигдаж байна.

Орон нутгийн нисэх буудлын аюулгүй ажиллагаанд тавих хяналт, нисэх буудлын ашиглалтын үр дүн хангалтгүй байна.

2.40 ИНД-140-ын дагуу нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ эрхлэх хүсэлтийг 2010-2015 оны хооронд 18 байгууллага ирүүлж гэрчилгээжсэнээс “Чингис хаан” ОУНБ, Гурвансайхан, Доной, Ховд, Чойбалсан, Мөрөн, Булган, Алтай, Баянхонгор, Баян-Өлгий, Тосонцэнгэл, Дэглий цагаан нисэх буудлууд, “Эй Си Эйч Сервисес” ХХК-иудын нисэхийн аюулгүй байдлын үзлэг шалгалт, харуул хамгаалалт, камерын хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны гэрчилгээ хүчинтэй байна.

2.41 ЗТСайдын 2016 оны 94 дүгээр тушаалаар “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр”-ийн дагуу хэрэгжүүлсэн ажлын тайлан гаргаагүй байна.

2.42 НААХЗАлба 2016 онд үйл ажиллагааны явцад хийсэн хяналт шалгалтаар байцаагчийн нийт 926 дүгнэлтээр 254 зөрчлийг, 2017 онд нийт 947 дүгнэлтээр 274 зөрчлийг 1-р зэрэглэл буюу ИНТХуулийн холбогдох зүйл, заалтыг, 2-р зэрэглэл буюу ИНД-ийн холбогдох шаардлагуудыг, 3-р зэрэглэл буюу ИНЕГ-аас баталсан холбогдох заавар, журмын шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчлүүд гарчээ.



2.43 Аудитын явцад НААХЗАлбаны байцаагчийн 2016-2017 онд гаргасан дүгнэлт, илрүүлсэн зөрчлийг үйл ажиллагааны чиглэлээр /өмнө нь зөрчлийн нэгтгэлийг гаргадаггүй, мэдээллийг боловсруулаагүй/ ангилуулан судалгаа хийж үзэхэд:

- ✚ Аэродромын чиглэлээр 2016 онд 25 дүгнэлтээр 38 зөрчил илрүүлж тухайн онд биелэлт 68.2%, 2017 онд 29 дүгнэлтээр 46 зөрчил илрүүлж биелэлт 19.6%,
- ✚ Нислэгийн хяналт зохицуулалтаар 2016 онд 21 дүгнэлтээр 6 зөрчил илрүүлж биелэлт 33.3%, 2017 онд 21 дүгнэлтээр 6 зөрчил илрүүлж биелэлт 33.3%,
- ✚ Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ 2016 онд 37 дүгнэлтээр 4 зөрчил илрүүлж биелэлт 50.0%, 2017 онд 57 дүгнэлтээр 48 зөрчил илрүүлж биелэлт 39.6%-тай байгаа нь зөрчлийн тоо өмнөх оноос өссөн, зөрчлийн биелэлт хангалтгүй байгаа нь орон нутгийн нислэгийн аюулгүй ажиллагаанд тавих хяналтыг шаардлагын түвшинд хүргэж ажиллаагүйг нотолж байна.

2.44 Дээрхээс үзэхэд байцаагчийн дүгнэлтээр өгсөн зөрчлийн дүн, мэдээлэлд судалгаа, шинжилгээ хийдэггүй, орон нутгийн нислэгийн аюулгүй ажиллагаанд тавих хяналтын үр нөлөө хангалтгүй байна.

2.45 ИНЕГ-аас гэрчилгээжсэн бүх байгууллага 9898 утсанд осол, зөрчлийн мэдээллийг өгдөг бөгөөд утсаар авсан мэдээллийг дэвтэрт бүртгэж, удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангаж байгаа ч аюулгүй ажиллагааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх, мэдээллийг зөрчлийн агуулга, шинж чанараар нь ангилдаггүй байна.

2.46 Энэ нь “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр”-ийн 6.2.3.4-т “Аюулгүй ажиллагааны мэдээллийг цуглуулах, ашиглах, дүн шинжилгээ хийх, харилцан солилцох ажиллагааг оновчтой зохион байгуулах, цахим мэдээллийн систем нэвтрүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилладаггүйтэй холбоотой байна.

“Чингис хаан” ОУНБ-ын үлдэх барилга байгууламжийг цаашид хэрхэн шийдвэрлэх асуудал тодорхой бус байна.

2.47 “Чингис хаан” ОУНБ нь нийт 93 нэр төрлийн 100,093.6 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгөтэй, нийт 15977 м2 талбайд жил бүр 424.5 сая төгрөгийг газрын төлбөрт төлж байна.

2.48 “Чингис хаан” ОУНБ нь “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-д нүүлгэн шилжүүлэхэд Иргэний Нисэхийн ерөнхий газраас одоогийн барилга байгууламжийн цаашдын эзэмшил, ашиглалтын талаарх /ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа, иргэний нисэхийн сургалт, дадлагын үйл ажиллагаа, бүсийн агаарын хөдөлгөөний удирдлага, тусгай үүргийн нислэгийн төв бий болгох/ санал, тооцоо судалгааг боловсруулан 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/227 дугаартай албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн ч цаашид барилга байгууламжуудыг хэрхэн ашиглах тодорхой чиглэл гараагүй байна.

2.49 Мөн ИНЕГ-аас ИНД-121.95, 121.157, 161, 95-ийн шаардлагын дагуу агаарын тээвэрлэгч нарын нисэн очих, нисэн гарах нисэх буудалтай /цаг агаарын хүндэрсэн, онцгой нөхцөл байдал үүссэн, аргагүйдсэн буулт үйлдэх, нислэг үйлдэж буй агаарын зам дагуу гэнэтийн нөхцөл байдалд тохиолдох үе зэрэгт/ ойрхон тухайн агаарын хөлгийн аэродромын хяналтын код, гэрчилгээжсэн аэродромтой тохирох нөөц аэродромыг бий болгох шаардлагатай байна.

Нисэх буудлын ашиглалтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнгүй, шинээр барьж байгаа аэродромын өртөг өндөр байна.



2.50 Говь-Алтай аймгийн Нисэх буудлын хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажил нь 2008 оноос эхэлсэн¹⁰, уг ажлын гэрээнд нийт 6 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан, Улсын комисс 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр актаар барилгын ажлыг хүлээн авсан байна.

2.51 Уг хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажилд үнийн өсөлтөөр 2 удаа нийт 4,661.7 сая төгрөгөөс 161.7 сая төгрөгийг ИНЕГ-ын цэвэр ашгаас “Заабар” ХХК-д олгосон байна.

2.52 2013 оны гэрээ дүгнэсэн актын 3-т “...4.5 тэрбум төгрөгийн хэмжээгээр үнийн тохируулга хийх”¹¹, 4-т “...үнийн өсөлтийг 4.5 тэрбум төгрөгөөр тооцон гаргаж, ...мөн дүнгээр ЗТЯаманд хуваарилагдсан,” ... гэж бичсэн байна.

2.53 Үүний дагуу 4.5 тэрбум төгрөгийн үнийн тохируулга хийсэн талаар ЗТЯамнаас тодруулга авахаар ИНЕГ 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/780 дугаартай албан бичгийг хүргүүлсэн ч аудитын явцад хариу ирүүлээгүй болно.

2.54 Дээрх ажлын нийт төсөвт өртөг 11,459.8 сая төгрөг, бусад ижил төстэй 11 нисэх буудлын балансын дундаж үнэтэй харьцуулахад 2.6 дахин их өртгөөр хийгджээ.

2.55 Завхан аймгийн “Доной” нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажил¹² 2008 оноос эхэлсэн, гэрээний анхны үнэ 8,651.5 сая, гэрээнд нийт 8 удаа нэмэлт өөрчлөлт оруулж, сүүлийн гэрээний хугацаа 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр дууссан байна.

2.56 Уг ажилд үнийн өсөлтөөр 2 удаа нийт 2,242.5 сая төгрөгийг олгохоор¹³ зааж, нийт төсөвт өртөг 10,894.0 сая төгрөг байгаа ба гүйцэтгэгч “Хурдны зам” ХХК-д нийт 8,327.2 сая төгрөгийн санхүүжилт олгож, барилгын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

2.57 Дээрх ажлын явцын талаар хэлэлцсэн 2013 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хурлын тэмдэглэлд¹⁴ “...“Хурдны зам” ХХК техникийн шаардлагад¹⁵ заагдаагүй ПБВ-90 витумд туршилт хийлгэхэд уян чанар батлагдсан нормын дагуу гараагүй, хөндлөнгийн хяналтын дүгнэлтээр витумыг 150^С-аас дээш температурт халааснаас витумын чанар алдагдсан...” гэж дурдсанаас үзэхэд ажлын чанарт доголдол гарч байсныг гэрчилж байна.

2.58 Завхан аймгийн “Доной” нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлыг үргэлжлүүлж дуусгах талаар ЗТХЯамнаас 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдөр ИНЕГ-т чиглэл өгсөн ч, ажлын гэрээг сунгасан эсэх, байгууламжийг хэзээ дуусгах нь тодорхойгүй байна.

¹⁰ 2008.02.27-ны өдрийн № ИНЕГ ТББ/БУ-5507 тоот гэрээг ЗТАЖЯ, “Заабар” ХХК нар баталж /захиалагчийг төлөөлж ИНЕГ, гүйцэтгэгчийг төлөөлж “Заабар” ХХК/, гэрээний дүнг 7,385.3 сая төгрөгөөр байгуулсан байна.

¹¹ МУ-ын 2013 оны улсын төсвийн тухай хуулийн ХХ.1.2.2.48 дэх заалт, МУИХ-ын ТБХорооны 2012.11.09-ны өдрийн 9/3117 тоотыг үндэслэн

¹² 2008.01.31-ны өдрийн № ИНЕГ ТББ/БУ-56-07 дугаар гэрээг ЗХАЖЯам, “Хурдны зам” ХХК нар баталж, /захиалагчийг төлөөлж ИНЕГ, гүйцэтгэгчийг төлөөлж “Хурдны зам” ХХК/,

¹³ ИНЕГ ТББ/БУ-56-07 тоот 2009.08.06-ны өдрийн гэрээнд 348.8 сая төгрөг, 2017.07.05-ны өдрийн гэрээнд 1,893.7 сая төгрөгийн үнийн өсөлт.

¹⁴ Захиалагч ИНЕГ, гүйцэтгэгч “Хурдны зам” ХХК, МХЕГ-ын хамтарсан

¹⁵ техникийн шаардлагын дагуу 90/130 витумаар хийх

**БҮЛЭГ 3****Иргэний нисэхийн салбарын боловсон хүчний зарим үйл ажиллагаа хангалтгүй байна.**

3.1 ИНЕГ-ын даргын 2015 оны А/833 дугаар тушаалаар “Иргэний нисэхийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг боловсруулж, батлуулсан байна.

3.2 Дээрх хөтөлбөрийн зорилго нь салбарын үйл ажиллагааны тэргүүлэх стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн хүний нөөцийг үр дүнтэй, тасралтгүй хөгжүүлэх нэгдсэн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх механизмыг бий болгоход оршсон байна.

3.3 Энэхүү хөтөлбөр нь 2020 он хүртэл салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх, ажлын үнэлгээний цогц системийг бий болгох зэрэг асуудлыг хамарчээ.

3.4 ИНЕГ нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг 2016-2017 оны байдлаар гаргасан ба хөтөлбөрийн хэрэгжилт 80.0-88.6 хувьтай тус тус дүгнэгдсэн байна.

3.5 Хөтөлбөрийн 3.1 дэх хүрээний зорилт 3-т: “Иргэний нисэхийн салбарын ажилтнуудыг бэлтгэх, дадлагажуулах, давтан сургах замаар залгамж халааг бэлтгэх хөтөлбөрийг боловсруулж, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх” гэж заасны дагуу ИНЕГ-ын даргын 2015 оны А/835 дугаар тушаалаар “Ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах, ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр”-ийг боловсруулж, үүний дагуу төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.6 ИНЕГ, түүний харьяа байгууллагуудын ажилтнуудыг ажил үүргээ гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, эзэмшсэн мэдлэг, боловсрол, мэргэшлийн ур чадвар, дадлага туршлагыг хадгалах, дээшлүүлэхэд оршсон байна.

2016-2017 онуудад зохион байгуулагдсан зарим сургалт ач холбогдлоо өгч чадаагүй байна.

3.7 ИНЕГ нь 2016-2017 онуудад нийт 9,182.0 сая төгрөгийн сургалтын зардал гаргаснаас гадаадад сурч байгаа оюутны зардалд 5,204.1 сая, ажилтнуудыг гадаадад бэлтгэх мэргэжлийн богино хугацааны сургалтын зардалд 3,719.2 сая, дотоод сургалтын зардалд 258.6 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.8 Иргэний нисэхийн сургалтын төвд зохион байгуулагдах 2016 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 53 сургалтанд 1240 ажилтанг 58.4 сая төгрөгийн зардалтайгаар, мөн төлөвлөгөөт бус 5 сургалтад 116 ажилтанг 0.8 сая төгрөгөөр сургасан, захиалгат төлбөртэй 11 сургалтанд 182 ажилтанг хамруулж, 22.6 сая төгрөгийн орлого олсон, харин 2017 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 40 сургалтанд 1706 ажилтанг хамруулжээ.

3.9 Мэргэжлийн сургалтын төв болон их, дээд сургуульд хийгдэх 2016-2017 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 45 байгууллагад төлөвлөгөөт 160, төлөвлөгөөт бус 26 сургалтыг 258.6 сая төгрөгийн зардал гаргаж зохион байгуулсан ба хэрэгжилт 81 хувьтай байна.

3.10 “Ажилтнуудыг мэргэшүүлэх, давтан сургах, ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр”-ийн 2.2.2-т: “Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ба хөгжүүлэх



бодлого, зорилт, холбогдох дүрэм, журам, шаардлагатай төсөв, хөрөнгө оруулалтыг ИНЕГ-ын дарга батална.” гэж заасан боловч гадаад улс оронд мэргэжилтэн бэлтгэх тусгайлсан журмыг боловсруулж ажиллаагүй ба уг тэтгэлэгт хамрагдах оюутныг хэрхэн сонгон шалгаруулах, сургалтын болон барьцааны гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, төгсөөд ирсэн оюутныг ажлын байраар хангах эсэх нь тодорхой бус байна.

3.11 Гадаадын Их, дээд сургуулиудад гэрээгээр тэтгэлэгт хамрагдсан оюутнуудын судалгааг 2016-2017 оны байдлаар гаргуулж авахад, шинээр гэрээ байгуулсан 38 хүнээс ИНЕГ-ын 14 үндсэн ажилтан, 24 хамааралгүй гадны хүмүүс байгаа ба түүнд 1,223.9 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

3.12 Дээрхээс 37 нь нисэхийн үндсэн мэргэжлээр, 1 хүн чанарын удирдлагын мэргэжлээр суралцаж байгаа ба бакалавр-25, магистрантур-7, докторантур-2, мэргэжлийн сургалтад 4 оюутан хамрагдсан байна.

3.13 2016-2017 онуудад гадаад улс оронд суралцсан 85 төгсөгчөөс 58 төгсөгч ажлын байраар хангагдсанаас ИНЕГ, түүний харьяа албанд 39, МИАТ ХК-д 7, Хувийн авиа компанид 8, гадны байгууллагад 4 төгсөгч ажиллаж байна. Дээрх төгсөгчдийн 90.6 хувь нь агаарын тээврийн салбарын, 9.4 хувь нь бусад мэргэжлээр /олон улсын гадаад харилцаа, эдийн засагч, Орос-Англи-Франц хэлний орчуулагч, бизнесийн удирдлага, олон улсын бизнес, улс төр, гадаад харилцаа/ суралцаж төгссөн нь үр ашиггүй хөрөнгө зарцуулагджээ гэж үзлээ.

3.14 “Гүрэн” дээд сургуультай Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал ашиглалтад оруулахтай холбогдуулан ИНЕГ-ын алба, салбаруудын ажилтануудад иргэний нисэхийн салбарын менежмент, нисэх буудал газрын үйлчилгээ, ачаа тээвэр, аюулгүй байдлын чиглэлийн сургалтуудыг зохион байгуулж, сургагч багш нарыг бэлтгэх, нисэх буудлын ажилтан, албан хаагчдын мэргэжлийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх ИНЕГ/УЗ/ТББ/У-18/17 дугаартай сургалтын гэрээг 2017 оны 08 дугаар сарын 01-ний өдөр 640.0 сая төгрөгөөр байгуулжээ.

3.15 Үүний дагуу ИНЕГ-ын даргын 2017 оны А/618 дугаартай тушаалаар сургалт зохион байгуулах, 2017 оны А/837 дугаартай тушаалаар сургалтад хамруулах тухай тушаал тус тус гарч, ажилчдыг сургалтад хамруулж сургалтын төлбөрт 512.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба сургалттай холбоотой асуудал Эрүүгийн цагдаагийн газарт хянагдаж байна.

3.16 Аудитын явцад санал, асуулга авахад, сургалтын үр дүнг оролцогчдын 7.6 хувь нь маш сайн, 49.5 хувь нь сайн, 31.4 хувь нь дунд, 8.6 хувь нь муу, 2.9 хувь нь маш муу гэж дүгнэсэн ба сургалтад хамрагдагсдын 63 хувь нь хугацаа бага, 5 өдрийн сургалт явагдахаас танхимын болон онлайн сургалт 1 удаа явагдаж, суралцагсдад сертификат олгоогүй, нөгөө талаас сургалтын явц, чанар, үр дүнг үнэлж, гэрээг дүгнээгүй зэрэг нь сургалт ач холбогдлоо өгч чадаагүйг харуулж байна.

3.17 Энэ нь ИНЕГ-ын даргын 2017 оны А/618 дугаар тушаалын 3-т: “Сургалтад хамрагдах ажилтнуудын суралцах хугацааны ажил үүрэгт зохицуулалт хийж, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг харьяа алба, салбаруудын дарга нарт сургалтад хамрагдах ажилтнуудын сургалтын үр дүн, чанарт хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосугай.” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.



Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах зарим асуудалд хууль эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна.

3.18 Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д: “Салбарынхаа хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давшан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх” гэсэн заалтын хүрээнд 2017 онд “Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулаагүй байгаа нь ажилтнуудын цалин, хөлсийг нэмэгдүүлэх, ажиллах нөхцөлийг сайжруулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх, эрүүл мэндийг сахин хамгаалах эсэх тодорхой бус байна.

3.19 ИНЕГ-ын даргын 2014 оны А/83 дугаартай тушаалаар 2013-2016 онд хэрэгжүүлэх “Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг баталсан бөгөөд дөрөв дэх хэсгийн зорилт 3.1-д: “Орон сууцны хөнгөлөлт үзүүлэх механизмыг боловсронгуй болгох” гэсний дагуу “Орон сууцны хөнгөлөлт олгох журам”-ыг ИНЕГ-ын даргын 2015 оны А/676 дугаар тушаалаар шинэчлэн баталж, мөрдөж ажилласан байна.

3.20 Дээрх журамд орон сууцны хөнгөлөлтийн хэмжээг тодорхой заагаагүйгээс зөвхөн удирдлагын түвшинд шийдвэрлэж байгаа нь ажилтнуудад /10.0 сая төгрөгөөс-110.0 сая төгрөг хүртэл/ харилцан адилгүй хөнгөлөлтийг олгоход хүргэсэн байна.

3.21 2016-2017 онд 147 хүнд орон сууцны дэмжлэг болгож 2,854.8 сая төгрөг зарцуулсан, үүнээс ЗТХЯамны 3 ажилтанд 35.8 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлт олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.6-д: “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.22 Мөн “Орон сууцны хөнгөлөлт олгох журам”-ийн 2.1.1-д: “ИНЕГ, түүний харьяа байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, үндсэн ажилтан байна”, 2.2.1-д: “Урьд өмнө улсаас буюу байгууллагаас орон сууц авсан болон орон сууцны үнийн хөнгөлөлт эдэлсэн бол орон сууцны хөнгөлөлт олгохгүй” гэснийг тус тус мөрдөөгүйгээс шалгуур үзүүлэлт хангаагүй 1 ажилтанд 20.0 сая, орон сууцны хөнгөлөлтийг давхардуулж 1 ажилтанд 22.0 сая төгрөг тус тус олгожээ.

Үйл ажиллагааны хэтийн болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж ажиллаагүй байна.

3.23 Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4-д: “Агентлагийн хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн төслийг хуульд заасан нөхцөл, үндэслэлээр хугацаанд нь боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид оруулах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

3.24 ИНЕГ нь 2016-2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого, ЗТСайдын /хуучин нэрээр/ 2014 оны 172 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан ба түүний хэрэгжилт 94 хувьтай байна.



ИНЕГ-ын бүтэц, орон тоонд тусгагдаагүй албаны үйл ажиллагааг санхүүжүүлж байна.

3.25 Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д: “Агентлагийн орон тооны дээд хязгаарыг Засгийн газар, агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг Засгийн газраас тогтоосон ерөнхий загварыг баримтлан Монгол Улсын сайд батална.” гэж заасны дагуу МУЗГ-ын 2016 оны 04 дүгээр тогтоолоор ИНЕГ-ын орон тооны дээд хязгаарыг 106 байхаар баталсан боловч ИНЕГ-ын даргын 2016 оны А/728 дугаар тушаалаар Агентлагийн орон тоог 100 байхаар баталсан, харин ЗТХЯ-ны харьяа Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны 6 орон тоог батлаагүй байгаа нь дээрх тогтоолын заалтыг зөрчихөд хүргэсэн байна.

3.26 Харин ЗТС-ын /хуучин нэрээр/ 2015 оны 340 дүгээр тушаалаар “Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба”-ны зохион байгуулалтын бүтцийг баталж, мөн өдрийн 341 дүгээр тушаалаар Албаны төсвийг баталж, санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлж ажиллахыг ИНЕГ-т даалгаснаар 2015-2017 онуудад 1,214.8 сая төгрөгийн зардлыг гаргасан ба байгууллагын орон тоонд хамааралгүй албыг санхүүжүүлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.6.6-д: “Тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ИНЕГ-ын бүтэц, орон тоонд 2015-2016 онуудад 2 удаа өөрчлөлт хийгджээ.

3.27 ЗТС-ын /хуучин нэрээр/ 2015 оны 239 дүгээр тушаал “Зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай”, ЗТХСайдын 2016 оны 70 дугаар тушаал “Бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” бүтцэд орсон өөрчлөлтийг харьцуулахад Хөрөнгө оруулалтын тасаг, Хууль, эрх зүйн газар, Шалгалтын нислэг, зураглалын албууд хасагдаж, Худалдан авах ажиллагааны хэлтэс, Нислэгийн журам боловсруулалтын алба, Дотоод аудитын алба, Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны алба, Ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх тасаг шинээр бий болсон байна.

3.28 ИНЕГ-ын даргын 2015 оны А/593 дугаар тушаал “Орон тоог шинэчлэн батлах тухай”, ИНЕГ-ын даргын 2016 оны А/728 дугаар тушаал “Орон тоог шинэчлэн батлах тухай” орон тооны өөрчлөлтийг харьцуулахад Тэргүүн дэд даргын орон тоо нэгээр, Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанд Менежерийн орон тоо хоёроор тус тус нэмэгджээ.

3.29 ЗТХСайдын зөвлөлийн 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны шийдвэрээр “ИНЕГ-ын бүтэц, зохион байгуулалтыг менежментийн түвшинд сайжруулах төсөл боловсруулж, танилцуулах” үүрэг даалгавар өгсөний дагуу ИНЕГ-ын даргын 2017 оны А/623 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, ИНЕГ болон түүний харьяа алба, салбаруудын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх асуудлыг хэлэлцэж, ИНЕГ-ын зохион байгуулалтын бүтцэд нэмэлт, өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулсан байна.

3.30 Тухайлбал, ИНЕГ-ын серверүүд болон програм хангамжийг холбох, нэгдсэн нэг сүлжээг дэлхийн бусад серверүүд рүү холбох, кибер аюулгүй байдлыг хангах асуудлыг зохицуулах, бусад алба, салбарыг мэдээллийн технологийн нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий, нэгж шаардлагатай байгаа тул “Мэдээллийн технологийн алба”-ыг шинээр бий болгохоор саналд оруулжээ.



БҮЛЭГ 4

2016-2017 оны зарим санхүү, эдийн засгийн төлөвлөлт бодитой бус, зардлын гүйцэтгэл үр дүн багатай байна.

4.1 ИНЕГ-ын санхүү, эдийн засгийн хэлтэс 2016 оны санхүүгийн тайланд, 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд тус тус шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

4.2 Дээрх шинжилгээний үр дүнд үндэслэн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ тодорхойгүй байна.

4.3 Аудитаар Сангийн сайдын 2015 оны 343 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайланд шинжилгээ хийх үлгэрчилсэн загвар"-ын дагуу 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүн шинжилгээг хийж гүйцэтгэв.

4.4 Уг шинжилгээний гол зорилго нь байгууллагын санхүүгийн хөрөнгийн байдал, орлого бүрдүүлэлт, хөрөнгийн зарцуулалтын байдлыг үнэлж дүгнэлт өгөхөд оршсон.

Нийт өр төлбөр өмнөх оноос 11.9 хувиар буурч, урт хугацаат өр төлбөр 40.8 хувиар нэмэгджээ.

1. ХӨРӨНГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ШИНЖИЛГЭЭ

4.5 Хүснэгт 3: Санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн бүрэлдэхүүний динамик шинжилгээ сая төгрөг

Үзүүлэлт	2016 он	%	2017 он	%	Өөрчлөлт Тоогоор	Хувиар
<i>Хөрөнгийн бүрэлдэхүүн</i>						
Эргэлтийн хөрөнгө	95,029.9	33.7	121,059.7	40.2	26,029.8	27.4
Эргэлтийн бус хөрөнгө	187,171.0	66.3	179,915.8	59.8	(7,255.2)	(3.9)
Дүн	282,200.9	100.0	300,975.5	100.0	18,774.6	6.7
<i>Эх үүсвэр</i>						
Өр төлбөр	10,704.5	3.8	9,433.5	3.1	(1,271.1)	(11.9)
Эзэмшигчийн өмч	271,496.4	96.2	291,542.0	96.9	20,045.6	7.4
Дүн	282,200.9	100.0	300,975.5	100.0	18,774.6	6.7

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.6 Хүснэгтээс үзэхэд санхүүгийн байдлын тайлангийн нийт эргэлтийн хөрөнгө 121,059.7 сая төгрөг болж өмнөх оноос 27.4 хувиар өссөн бол эргэлтийн бус хөрөнгө 179,915.8 сая төгрөг болж өмнөх оноос 3.9 хувиар буурсан нь дуусаагүй барилгыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

4.7 Нийт өр төлбөр 9,433.5 сая төгрөг болж өмнөх оноос 11.9 хувиар буурсан боловч тайлант онд богино хугацаат өр төлбөр нь өмнөх оноос 27.0 хувиар буурсан, харин урт хугацаат өр төлбөр нь 40.8 хувиар нэмэгдэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар орж ирсэн мөнгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн нь нөлөөлжээ.

4.8 Эздийн өмч өмнөх оноос 7.4 хувиар өссөн нь гадаадын байгууллагаас хандиваар ирсэн үндсэн хөрөнгүүдийг эздийн өмчийн бусад хэсэгт бүртгэсэнтэй холбоотой байна.



Санхүүгийн хувьд тогтвортой, төлбөрийн чадвартай байгаа нь өр төлбөрөө барагдуулах боломжтойг харуулж байна.

Б. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

4.9 Хүснэгт 4: Төлбөрийн чадварын шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт
Цэвэр эргэлтийн хөрөнгө (сая.төг)	86,717.99	114,993.88	33%
Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	10.68	18.48	7.80
Эргэлтийн харьцаа	11.43	19.96	8.53
Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.34	0.40	0.06
Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин	0.91	0.95	0.04

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.10 Хүснэгтээс үзэхэд 2017 оны байдлаарх түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа нь 7.8 пунктээр, эргэлтийн харьцаа нь 8.5 пунктээр, эргэлтийн хөрөнгийн хувийн жин 0.06 пунктээр, цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин 0.04 пунктээр тус тус өмнөх оноос өссөн нь эргэлтийн харьцаа, түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа А түвшинд буюу төлбөрийн чадвартайг илэрхийлснээр өр төлбөрөө барагдуулах боломжтойг нотолж байна.

4.11 Хүснэгт 5: Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт
Бие даах чадварын коэффициент	0.96	0.97	0.01
Санхүүгийн хамаарлын коэффициент	1.04	1.03	(0.01)
Зохицуулалтын коэффициент	0.35	0.39	0.04
Өр төлбөрийн хувийн жин	0.04	0.03	(0.01)
Өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа	0.04	0.03	(0.01)

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.12 Хүснэгтээс харахад өр төлбөрийн хувийн жин болон өр төлбөр ба эздийн өмчийн харьцаа нь 0.01 пунктээр буурч, бие даах чадварын коэффициент 0.01 пунктээр, зохицуулалтын коэффициент 0.04 пунктээр тус тус өссөн байгаа нь санхүүгийн тогтвортой байдлын хувьд А түвшинд буюу хангалттайг харуулж байна.

4.13 Хүснэгт 6: Эргэцийн шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт
Авлагын эргэц (удаа)	4.68	7.28	2.60
Авлагын эргэц (өдөр)	76.89	49.47	(27.42)
Бараа материалын эргэц (удаа)	24.16	13.26	(10.90)
Бараа материалын эргэц (өдөр)	14.9	27.16	12.26
Эргэлтийн хөрөнгийн эргэц (удаа)	2.52	2.61	0.09
Эргэлтийн хөрөнгийн эргэц (өдөр)	142.6	138.08	(4.52)
Нийт хөрөнгийн эргэц	0.82	0.97	0.15
Өглөгийн эргэц (удаа)	107.87	59.45	(48.42)
Өглөгийн эргэц (өдөр)	3.34	6.06	2.72
Үйлдвэрлэлийн циклийн хугацаа	91.79	76.63	(15.16)
Санхүүгийн циклийн хугацаа	88.45	70.57	(17.88)

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.14 Хүснэгтээс үзэхэд авлагын эргэц 2.6 удаагаар өсч, 27.4 өдрөөр буурсан, бараа материалын эргэц 10.9 удаагаар буурч, 12.2 өдрөөр өссөн нь үйлдвэрлэлийн циклийн хугацаа өмнөх оноос 15.1 өдрөөр түргэсэхэд нөлөөлжээ.



4.15 Нийт хөрөнгийн эргэц 0.15 удаагаар өсч, өглөгийн эргэц 48.42 удаагаар түргэссэн, харин өглөгийн эргэц 2.72 өдрөөр өссөн нь санхүүгийн циклийн хугацаа өмнөх оныхоос 17.88 өдрөөр түргэсэхэд нөлөөлж энэ нь гадаадын агаарын тээвэрлэгчдийн авлагыг цаг хугацаанд нь барагдуулах ажлыг эрчимжүүлсэн, шинэ тоног төхөөрөмж ашиглалтад орсноор түүний дагалдах сэлбэг хэрэгсэл нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

4.16 Хүснэгт 7: Хөдөлмөрийн бүтээмжийн шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт
Хөдөлмөрийн бүтээмж /сая төгрөг/	6,261.1	8,645.0	38 %

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.17 Хүснэгтээс үзэхэд хөдөлмөрийн бүтээмж өмнөх оноос 38 хувиар өсөхөд нийт борлуулалтын хэмжээ нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгийн ашиглалт 0.05 пунктээр сайжирсан байна.

4.18 Хүснэгт 8: Үндсэн хөрөнгийн ашиглалтын шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт
Эдийн засгийн тогтвортой өсөлтийн коэффициент	0.05	0.07	0.02
Нийт хөрөнгийн ачаалал	0.81	0.94	0.13
Удаан гүйлгээтэй хөрөнгийн ачаалал	0.81	1.57	0.76
Өөрийн капиталын ачаалал	0.84	0.97	0.13
Үндсэн хөрөнгийн хувийн жин	1.18	1.04	(0.14)
Үндсэн хөрөнгийн нийт дүнд үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн эзлэх хувийн жин	0.87	0.98	0.11
Үндсэн хөрөнгийн элэгдлийн коэффициент	0.47	0.54	0.07
Үндсэн хөрөнгийн шинэчлэлтийн коэффициент	0.12	0.07	(0.05)
Үндсэн хөрөнгийн хасагдалтын коэффициент	0.04	0.03	(0.01)
Үр ашгийн коэффициент	0.07	0.12	0.05

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.19 Хүснэгтээс үзэхэд эдийн засгийн тогтвортой өсөлтийн коэффициент 0.02 пунктээр, нийт хөрөнгийн ачаалал 0.13 пунктээр, удаан гүйлгээтэй хөрөнгийн ачаалал 0.76 пунктээр, үр ашгийн коэффициент 0.05 пунктээр тус тус өссөн нь нийт борлуулалт болон хөрөнгө, цэвэр ашиг нэмэгдсэнтэй холбоотой байна.

4.20 Үндсэн хөрөнгийн элэгдлийн коэффициент 0.07 пунктээр нэмэгдсэн, үндсэн хөрөнгийн шинэчлэлтийн коэффициент 0.05 пунктээр, хасагдалтын коэффициент 0.01 пунктээр тус тус буурсан нь үндсэн хөрөнгийг бүрэн шинэчлэх боломжгүй байгаа ба тухайн онд актлагдсан үндсэн хөрөнгө урьд оныхоос бага байгаатай холбоотой байна.

Борлуулалтын орлого нэмэгдсэнээр ашигт ажиллагааны түвшин дээшилж, мөнгөн урсгал сайжирчээ.

4.21 Хүснэгт 9: Ашигт ажиллагааны шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт
Борлуулалтын ашигт ажиллагаа	0.09	0.07	(0.02)
Хөрөнгийн ашигт ажиллагаа (өгөөж)	0.05	0.09	0.04
Эздийн өмчийн ашигт ажиллагаа	0.05	0.07	0.02

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.22 Хүснэгтээс үзэхэд өмнөх оноос борлуулалтын ашигт ажиллагаа 0.02 пунктээр буурч, хөрөнгийн ашигт ажиллагаа 0.04 пунктээр, эздийн өмчийн ашигт



ажиллагаа 0.02 пунктээр тус тус өсөхөд борлуулалтын орлого, тайлант үеийн цэвэр ашиг нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

4.23 Хүснэгт 10: Мөнгөн урсгалын шинжилгээ, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Үзүүлэлт	2016 он	2017 он	Өөрчлөлт
Цэвэр эргэлтийн хөрөнгө ба борлуулалтын харьцаа	0.39	0.41	0.02
Цэвэр эргэлтийн хөрөнгө ба нийт хөрөнгийн харьцаа	0.31	0.38	0.07
Мөнгөн орлого ба борлуулалтын харьцаа	1.07	0.99	(0.08)
Мөнгөн орлого ба хөрөнгийн харьцаа	0.85	0.92	0.07
Мөнгөн зарлага ба борлуулалтын харьцаа	2.52	2.78	0.26

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.24 Хүснэгтээс үзэхэд өмнөх оноос цэвэр эргэлтийн хөрөнгө ба борлуулалтын харьцаа 0.02 пунктээр, цэвэр эргэлтийн хөрөнгө ба нийт хөрөнгийн харьцаа 0.07 пунктээр тус тус өссөн, харин мөнгөн орлого ба борлуулалтын харьцаа 0.08 пунктээр буурч, мөнгөн орлого ба хөрөнгийн харьцаа 0.07 пунктээр, мөнгөн зарлага ба борлуулалтын харьцаа 0.26 пунктээр тус тус нэмэгдсэн зэрэг нь борлуулалтын орлого өмнөх оныхоос 23.5 хувиар нэмэгдсэнээс шалтгаалж цэвэр эргэлтийн хөрөнгө, борлуулалтын орлого, нийт хөрөнгийн харьцаа урьд оныхоос өссөнтэй холбоотой байна.

Иргэний нисэхийн үйлчилгээний орлого нэмэгдэхэд навигацгийн орлогын өсөлт нөлөөлжээ.

В. ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ШИНЖИЛГЭЭ

4.25 ИНЕГ-ын үйл ажиллагааны орлого, зарлагыг төлөвлөхдөө урьд жилүүдийн гүйцэтгэлд тулгуурлаж, өнгөрөлтийн нислэгийн тоо, валютын ханш болон инфляцийн өөрчлөлт зэргийг харгалзсан байна.

4.26 Хүснэгт 11: ИНЕГ-ын 2016-2017 оны орлогын бүтэц

Үзүүлэлт	2016 он		2017 он		Өөрчлөлт /хувиар/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2017 гүйц. 2016 гүйц.	2017 гүйц. 2017 төл.	2017 төл. 2016 төл.
Өнгөрөлт	161,619.7	192,541.1	231,083.8	242,833.9	26.1	5.1	43.0
Буулт, хөөрөлт	8,978.9	11,060.6	8,211.0	11,750.0	6.2	43.1	(8.6)
Зорчигч үйлчилгээ	8,803.9	9,490.7	8,975.0	11,241.1	18.4	25.2	1.9
Бусад орлого	9,657.4	22,193.2	9,849.4	19,912.1	(10.3)	102.2	2.0
ҮХ данснаас хассаны олз	-	-	-	2.8	-	-	-
Улсын төсвийн санхүүжилт	-	8,407.2	-	4,189.2	(50.2)	-	-
Нийт орлогын дүн	189,059.9	243,692.8	258,119.2	289,929.1	19.0	12.3	36.5

сая төгрөг

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.27 Хүснэгтээс үзэхэд өмнөх оны төлөвлөлтөөс орлогыг 36.5 хувиар нэмэгдүүлж төлөвлөсөн нь 2017 онд агаарын навигацгийн хураамж бодох аргачлалыг өөрчлөнө гэж тооцсонтой холбоотой ба тухайн жилийн гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулахад 12.3 хувиар, өмнөх оны гүйцэтгэлээс 19 хувиар тус тус өсөхөд олон улсын нислэгийн өнгөрөлт болон буулт хөөрөлтийн тоо нэмэгдсэн нь нөлөөлжээ.



4.28 Хүснэгт 12: Олон улсын өнгөрөлтийн нислэгийн мэдээ

Маршрут	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	Нийт нислэг	Нийт нислэгт эзлэх %	Өмнөх оноос өссөн %	2013 оноос өссөн %
NIXAL-DARNO	15,219	15,872	15,028	14,239	13,746	74,104	15.67	(3.46)	(9.68)
GINOM-INTIK	11,112	11,376	12,114	12,286	12,823	59,711	12.63	4.37	15.40
DARNO-NIXAL	10,231	10,325	9,285	8,833	11,252	49,926	10.56	27.39	9.98
...	...	...	...	...	...	...	...	...	...
Нийт	85,689	87,117	90,686	99,210	110,953	473,655	100.00	11.84	29.48

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.29 Хүснэгтээс үзэхэд NIXAL-DARNO, GINOM-INTIK, DARNO-NIXAL замаар гүйцэтгэсэн нислэгийн тоо нийт нислэгийн дүнд 15.67-10.56 хувийг эзэлж байгаа бөгөөд 2013 онтой харьцуулахад нийт нислэг 29.48 хувиар өсч 110,953-д хүрсэн ба өмнөх онтой харьцуулахад POLHO-AMUTA, NOPUS-INTIK, INTIK-NOPUS, SERNA-MORIT, MORIT-SERNA, NOPUS-MORIT, NOPUS-SARUL зэрэг чиглэлүүд 100-аас дээш хувиар нэмэгдсэн нь нийт нислэгийн тоо 11.84 хувиар өсөхөд нөлөөлжээ.

4.30 Хүснэгт 13: ИНЕГ-ын 2016-2017 оны зардлын төлөвлөлт, гүйцэтгэл

сая төгрөг

Үзүүлэлт	2016		2017		Өөрчлөлт /хувиар/		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2017 гүйц. 2016 гүйц.	2017 гүйц. 2017 төл.	2017 төл. 2016 төл.
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	50,972.8	52,287.4	65,929.7	60,489.1	15.7	(8.3)	29.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,296.2	2,349.7	3,796.6	3,264.6	38.9	(14.0)	15.2
Хангамж, бараа материалын зардал	4,937.8	4,764.6	6,028.9	5,030.5	5.6	(16.6)	22.1
Нормативт зардал	1,615.4	1,374.7	1,841.7	1,203.2	(12.5)	(34.7)	14.0
Эд, хогшил урсгал засварын зардал	3,470.7	3,302.1	4,254.7	3,050.3	(7.6)	(28.3)	22.6
Томилго, зочны зардал	1,012.2	1,016.0	1,044.8	926.1	(8.8)	(11.4)	3.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,030.4	2,983.8	6,379.2	2,649.4	(11.2)	(58.5)	214.2
Бараа үйлчилгээний бусад зардал	17,015.9	13,659.0	17,457.0	11,857.7	(13.2)	(32.1)	2.6
Үйл ажиллагааны бусад зардлын дүн	4,686.9	4,383.8	9,630.0	6,872.4	56.7	(28.6)	105.5
Нийт зарлага	89,038.3	86,121.1	116,362.5	95,343.4	10.7	(18.1)	30.7

Эх сурвалж: Аудитын багийн тооцоо, шинжилгээ

4.31 ИНЕГ нь 2017 онд өмнөх оны төлөвлөгөөнөөс төсөвт зардлыг 30.7 хувиар өсгөж төлөвлөсөн нь Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны алба 191 орон тоотойгоор шинээр бий болсон, ажилчдын хоолны хөнгөлөлтийг 5500 төгрөгөөр нэмэгдүүлсэн, Ази номхон далайн орнуудын Иргэний нисэхийн байгууллагын захирлуудын 54 дүгээр чуулган зохион байгуулсан, Шүүхийн шийдвэрээр төлөх зардлыг нэмсэн зэрэгтэй холбоотой байна.

2016-2017 онд нийт батлагдсан төсөвт зардлын 86.9 хувийг ашиглажээ.

4.32 2016 онд нийт зардал 89,038.3 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 86,121.1 сая төгрөг гарсан ба нийт зардлын 56.4 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, 6.4 хувийг нийгмийн даатгалын шимтгэл, 2.8 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 5.7 хувийг хангамж, бараа материалын зардал, 3.9 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 24.8 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

4.33 2017 онд нийт зардал 116,362.5 сая төгрөгөөр батлагдсанаас, гүйцэтгэлээр 95,343.4 сая төгрөг гарч, нийт зардлын 63.4 хувийг цалин хөлс болон нэмэгдэл



урамшуулал, 6.5 хувийг нийгмийн даатгалын шимтгэл, 3.4 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 5.3 хувийг хангамж, бараа материалын зардал, 3.2 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 18.2 хувийг бусад зардал тус тус эзэлж байна.

4.34 Дээрхээс үзэхэд 2017 оны батлагдсан төсөвт зардлын 18.1 хувийг ашиглаагүй, шүүхийн шийдвэрээр гарсан 2,163.6 сая төгрөгийн зардлыг төсвийн тодотголд оруулж батлуулсан зэрэг нь төсвийн төлөвлөлтийн үндэслэл бодитой бус байгааг илэрхийлж байна.



Аудитын дүгнэлт

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.
Үүнд:

1. ИНЕГ-ын 2016-2017 оны мөнгөн хөрөнгийн ашиглалт, зарцуулалт үр ашиггүй байна.

- 1.1 Нийт орлогын 51.7 хувийг улсын төсвийн орлого бүрдүүлэхэд, 41.8 хувийг агентлаг, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зарцуулж, харин иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж ажиллаагүй байна.
- 1.2 ИНЕГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланг Зам, тээврийн хөгжлийн яаманд Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар, Сангийн яаманд Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалын дагуу тус тус тайлагнаж байгаа нь 2 өөр хэлбэрийн санхүүгийн тайлан давхар гаргахад хүргэж байгаа нь батламж мэдэгдлийн үнэн зөв байдал ба тасалбар болголт, үнэлгээ гэсэн шаардлагыг хангахгүй байна.
- 1.3 Аудитаар 136,403.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 113,460.2 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргасныг цаашид давтан гаргахгүй байх талаар зөвлөмж, 13,684.5 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага өгөхөөр шийдвэрлэж, харин ИНЕГ-ын зарим албан тушаалтнууд албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэм буруутай үйлдлээрээ байгууллага болон улсад 9,258.7 сая төгрөгийн хохирол учруулсан асуудлыг Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

2. Агаарын тээврийг хөгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний үр нөлөө хангалтгүй байна.

- 2.1 Агаарын навигацийн үйлчилгээний хэтийн чиг хандлагыг тодорхойлсон ч агаарын зайн ангилал, агаарын замуудад бүрэн дүн шинжилгээ хийгээгүй, баруун хэсгийн агаарын замаар нислэгийн эрчимжилт нэмэгдэх нөхцөлд агаарын хөлөгт үзүүлэх навигацийн үйлчилгээнд ADS-B системийг зайчлалд ашиглах шаардлага тавигдаж байна.
- 2.2 Орон нутгийн нисэх буудлын аюулгүй ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.
- 2.3 “Чингис хаан” ОУНБ-ыг “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-д нүүлгэн шилжүүлэхэд одоогийн барилга байгууламжийг цаашид хэрхэн эзэмших, ашиглах талаар тодорхой чиглэл гараагүй байна.
- 2.4 “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-ын төслийн үйл ажиллагааг тусдаа эрсдэлийн аудит хийж, дүгнэлт гаргах нь зүйтэй гэж үзлээ.



- 2.5 “Иргэний нисэхэд ашиглах агаарын зайн бодлогын баримт бичиг”-ийг Иргэний нисэхийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн холбогдох заалтын дагуу салбарын ямаар хянуулж батлуулаагүй байна.

3. Иргэний нисэхийн салбарын боловсон хүчний зарим үйл ажиллагаа хангалтгүй байна.

- 3.1 ИНЕГ нь гадаад улс оронд мэргэжилтэн бэлтгэх тусгайлсан журмыг боловсруулж ажиллаагүй ба уг тэтгэлэгт хамрагдах оюутныг хэрхэн сонгон шалгаруулах, сургалтын болон барьцааны гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, төгсөөд ирсэн оюутныг ажлын байраар хангах зэрэг асуудлууд тодорхой бус байна.
- 3.2 2016-2017 онуудад гадаад улс оронд суралцсан 85 төгсөгчөөс 58 төгсөгч ажлын байраар хангагдсан, 27 төгсөгч ажлын байраар хангагдаагүй хүний нөөцөд бүртгэлтэй байгаагаас үзэхэд суралцагсдын тоонд хязгаар тогтоож, байгууллагын зардлыг хэмнэж, үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч ажиллаагүй байна.
- 3.3 “Орон сууцны хөнгөлөлт олгох журам”-д орон сууцны хөнгөлөлтийн хэмжээ тодорхой бусаас шалтгаалж хүн бүрт харилцан адилгүй орон сууцны дэмжлэг олгож ирсэн байна.
- 3.4 ИНЕГ нь агентлагийн хэтийн болон дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулж, салбарын ямаар хянуулж батлуулаагүй, мөн “Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-т шинэчлэлт, өөрчлөлт оруулаагүй байна.

4. 2016-2017 оны зарим санхүү, эдийн засгийн төлөвлөлт бодитой бус, зардлын гүйцэтгэл үр дүн багатай байна.

- 4.1 2017 оны батлагдсан төсөвт зардлын 18.1 хувийг ашиглаагүй, шүүхийн шийдвэрээр гарсан 2,163.6 сая төгрөгийн зардлыг төсвийн тодотголд оруулж батлуулсан зэрэг нь төсвийн төлөвлөлтийн үндэслэл бодитой бус байна.
- 4.2 Шинжилгээний явцад удаан гүйлгээтэй үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргуулахад ИНЕГ-ын салбарын хэмжээнд 370.6 сая төгрөгийн үнийн дүн бүхий ашиглалтгүй хөрөнгө хуримтлагдсан байна.



Аудитын зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх-д:

1. ИНЕГ нь нийт орлогынхоо 51.7 хувийг улсын төсөвт төвлөрүүлж, харин иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд хөрөнгө зарцуулахгүй байгаа нь маш ноцтой бөгөөд аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал алдагдсанаас ирээдүйд их эрсдэл үүсэх магадлал өндөр тул цаашид урьдчилан сэргийлэх эрсдэлийн сан бүрдүүлэх арга хэмжээг авч шийдвэрлэх.
2. Агентлаг болон аж ахуйн нэгжийн хосолсон байдлаар үйл ажиллагаагаа явуулснаас санхүүгийн нэгтгэсэн тайланг 2 өөр хэлбэрээр давхар гаргаж байгаа тул бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож шийдвэрлэх.
3. “Чингис хаан” ОУНБ-ыг шинэ нисэх буудал руу шилжүүлсэн тохиолдолд одоогийн нийт 93 нэр төрлийн 100,093.6 сая төгрөгийн барилга байгууламжийн цаашдын эзэмшил, ашиглалтыг иргэний нисэхийн дүрмийн шаардлагын дагуу нөөц аэродромыг бий болгох, зориулалтын дагуу ашиглах арга хэмжээг авч, шийдвэр гаргах.

Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ-д:

1. “Иргэний нисэхэд ашиглах агаарын зайн бодлогын баримт бичиг”, ИНЕГ-ын хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө зэргийг холбогдох хуульд нийцүүлэн хянаж, батлах арга хэмжээг авах.

ИНЕГ-ын дарга Л.Бямбасүрэн-д:

1. Агаарын зайн ангилал, агаарын замуудын зохион байгуулалтад үе шаттайгаар дүн шинжилгээний ажлыг явуулах, автомат хамааралтай ажиглалтын ADS-B системийг зайчлалд ашиглах ажлыг эрчимжүүлэх.
2. Орон нутгийн нисэх буудлын аюулгүй ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.
3. Гадаад улс оронд мэргэжилтэн бэлтгэх тусгайлсан журмыг боловсруулах.
4. ИНЕГ-ын тэтгэлгээр гадаад улс оронд мэргэжил эзэмшиж ирсэн хүмүүсээс нөөцөд бүртгэлтэй боловсон хүчний судалгаа гаргаж, суралцсан төгсөгчдийг ажлын байраар хангах арга хэмжээ авч ажиллах.
5. “Орон сууцны хөнгөлөлт олгох журам”-д орон сууцны хөнгөлөлтийн хэмжээг тодорхойлох.
6. ИНЕГ-ын хэтийн болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж, дээд шатны байгууллагаар хянуулж, батлуулах арга хэмжээ авч ажиллах
7. Төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг эдийн засгийн бодит тооцоо, судалгаанд тулгуурлан боловсруулах
8. Ашиглалтгүй үндсэн хөрөнгийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх.

**Холбогдох байгууллагын санал**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**17120 Улаанбаатар хот, Хан -Уул дүүрэг, Буянт-Ухаа,
Утас: 28-20-64, Факс: (976-11) 28-21-02, (976) 7004-98252018.03.27 № 01/956
танай 2018.03.23 -ны № 01/784 -т**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ**

Танай газраас ирүүлсэн 2018 оны 01/784 тоот
албан бичигтэй танилцлаа.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016-2017 оны
үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн 1 дүгээр бүлгийн 27
дугаар асуудлын Ази номхон далайн бүсийн орнуудын
Иргэний нисэхийн ерөнхий захирлуудын 54 дүгээр
хурлын үйл ажиллагааг зохион байгуулах арга
хэмжээний зардлыг үр ашиггүй гэснийг зөвшөөрөхгүй
байгаа тул тайлангаас хасуулах саналтай байна.

Хавсралт 1 хуудастай.

ДАРГА

Л.БЯМБАСҮРЭН



08 1815



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**17120 Улаанбаатар хот, Хан -Уул дүүрэг, Буянт-Ухаа,
Утас: 28-20-64, Факс: (976-11) 28-21-02, (976) 7004-9825

2018.04.30 № 01/1375
танай 2018.04.23 -ны № 999 -Т

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
Д.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Тус газрын 2016-2017 оны үйл ажиллагааны
хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлд холбогдох саналыг үүгээр
хүргүүлж байна.

Хавсралт 15 хуудастай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН

08 2625



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНАЛ

Танай газраас "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016-2017 оны үйл ажиллагааны үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудит шалгалтаар илэрсэн зарим зөрчлүүдэд дараах тайлбарыг хүргүүлж байна. Үүнд:

1 дүгээр бүлгийн 22 дугаар асуудалд 2016-2017 онуудад хийгдсэн зарим нэгэн ажил гүйлгээ нь төсөвт зардлын үр ашиглалт үр нөлөө багатай,

Аудитын дүгнэлт: Ямар ч хууль эрх зүйн үндэслэлгүйгээр МИАТ ХК, Хүннү Эйр ХХК, Аэромонголиа ХХК-иудын нислэгийн нөхөн олговорт 301.1 сая төгрөг зарцуулсан байна.

ИНЕГ-ын санал: "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-ын баримт бичигт тусгагдсан орон нутгийн алслагдсан бүс нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулах ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Зам, тээврийн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 83 дугаар тушаалд "...Иргэний нисэхийн Ерөнхий газрын 2016 оны 01/802 тоот албан бичгийн хавсралтад заагдсан төсөл, арга хэмжээг зохих журмын дагуу хэрэгжүүлэх"-ийг зөвшөөрсөн мөн Сангийн сайдын 2017 оны 4-3/6325 тоот албан бичигт Агаарын тээвэрлэгчдийн нислэгийн статистик үзүүлэлтэд үндэслэн өвөлжилт хүндэрч цаг агаарын онц хүнд байдал бий болж болзошгүй, орон нутгийн авто зам хаагдсан, газрын тээврийн сүлжээ сул хөгжсөн, алслагдсан бүс нутгийн чиглэлд үйлчилгээ үзүүлж буй дотоодын агаарын тээвэрлэгчдэд нөхөн олговор олгож ажилласан. Нөхөн олговрыг дэмжиж ажилласнаар төрийн зайлшгүй үйлчилгээ болох нийгмийн үйлчилгээ авах хэрэгцээ шаардлагатай өндөр настан, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ шаардлагатай 900 орчим зорчигчдод зах зээлд борлуулагдаж буй тарифаас 32-37 хувийн хямд үнээр агаарын тээврийн үйлчилгээгээр дамжуулж, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж ажилласан.

Аудитын дүгнэлт: Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын барилга, байгууламж ашиглалтад орж, үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байхад түүнтэй холбоотой ашиглалтын болон урсгал зардалд 2017 онд 5,886.0 сая, төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

ИНЕГ-ын санал: Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл"-ийн зөвлөх компани (Азусса секкей-Ориенталс түншлэл) болон ерөнхий гүйцэтгэгч компани (Мицүбиши-Чиёода нэгдэл) үндсэн гэрээ (MON-P8, MON-P10)-нд тусгагдсан барилгын ажлыг төслийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд ИНЕГ-ын даргын 2016 оны 12 дугаар сарын 19-ний А/982 дугаар тушаалаар томилогдсон техникийн комисс ажиллаж санал дүгнэлтээ гаргасан. Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 123 дугаар тушаалаар томилогдсон Улсын комисс ажиллаж 2017 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн нисэх буудлын барилга, байгууламжуудыг Иргэний нисэхийн ерөнхий газарт хүлээлгэн өгсөн.

Тухайн үед ИНЕГ-ын бүтцэд шинэ нисэх буудлыг хүлээн авсан барилга, байгууламж, суурилагдсан машин, тоног төхөөрөмжийн засвар арчлалт, хадгалалт, хамгаалалтыг хариуцах нэгж байгаагүйн улмаас нийт 560 сая орчим ам.долларын өртөг бүхий барилга, байгууламж өвлийн улиралд хөлдөх, эзэнгүй орхигдох, тоногдох эрсдэл бий болсон бөгөөд тоног төхөөрөмжүүдийн туршилт, тохируулгыг гүйцэтгэж нислэгийн бэлэн байдлыг хангах, нисэх буудлыг гэрчилгээжүүлэхэд шаардлагатай баримт бичгийг боловсруулах зэрэг ажлууд хойшлох нөхцөл байдал үүссэн.

Иймээс дээрх эрсдэлүүдийг бууруулах, нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хангаж, сул зогсолтын хугацааг багасгах зорилгоор төслийн хүрээнд баригдсан барилга, байгууламж, машин, тоног төхөөрөмжүүдийг нислэг үйлдвэрлэл эхлэх хүртэлх хугацаанд хадгалж хамгаалах, засвар арчлалтыг хийж гүйцэтгэх, нисэх буудлын үйл



ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллах үндсэн чиг үүрэг бүхий **"Ашиглалтын өмнөх захиргааны алба"**–ны бүтэц батлагдсан.

Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA), болон төслийн ерөнхий гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын барилга байгууламжийг хүлээн авснаас хойш нислэг үйлдвэрлэл эхлэх хүртэлх хугацаанд гарах урсгал зардлыг Монгол Улсын Засгийн газар хариуцан ажиллах үүрэг хүлээсэн.

Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны алба нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 70 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн бүтцэд багтсан бөгөөд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Орон тоо шинэчлэн батлах тухай" 95 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын үйлдвэрлэлийн албадын бүтцэд "Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны алба" шинээр нэмж батлагдсан.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 14 дүгээр хуралдаанаар Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын талаар авах зарим арга хэмжээний талаар хэлэлцэж, Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтцэд үйл ажиллагаа явуулж буй Ашиглалтын өмнөх захиргааны албаны орон тоог нэмэгдүүлэх, үүнтэй холбогдуулан шаардагдах зардлыг санхүүжүүлэх асуудлыг хамтран шийдвэрлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат, Сангийн сайд Д.Чойжилсүрэн нарт зөвшөөрсөн байна.

Япон улсын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй төслийн нийт өртөгт /65,5 тэрбум иен/ бөгөөд Ашиглалтын өмнөх захиргааны алба нь нийт 17 үндсэн болон дагалдах барилга, байгууламж, объектын ашиглалтын үйл ажиллагаа, тэдгээрт суурилагдсан систем, тусгай тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт бүрэн бүтэн байдал, нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлэн байдлыг хариуцан ажиллаж байна. Үүнд:

- Зорчигч үйлчилгээний барилга
- I ап үнтраах, явран хамгаалах албаны барилга
- Цахилгааны үндсэн дэд өртөө
- Зорчигч үйлчилгээний генераторын байр
- Цэвэр усны байгууламж
- Гүний худгийн насосын 1, 2, 3 дугаар байгууламж
- Өргөлтийн насосын 1, 2 дугаар байгууламж
- Нислэгийн хяналтын цамхаг болон удирдлагын байр
- Нислэгийн хяналтын цамхгийн цахилгааны дэд өртөө
- Халаалтын зуухны барилга (42Мвт)
- Курсийн радио маякын байр
- Курсийн радио маякын цахилгааны дэд өртөө
- Бүх чиглэлтэй хэт өндөр давтамжийн радио дохиологч
- Глиссадын радио маякын байр
- Глиссадын радио маякын цахилгааны дэд өртөө
- Шатахуун хангамжийн байгууламж, гидрант систем (иж бүрэн)
- Бохир ус цэвэршүүлэх байгууламж
- Бусад байгууламжууд /"А кэмп", "А кэмп"-ийн халаалтын зуух, харуулын байр, үерийн далан, бусад дагалдах байгууламжууд/

Шинэ нисэх буудлын Дулаан хангамж, сантехникийн байгууламжийн үйл ажиллагааны бэлтгэл ажлын хүрээнд шаардлагатай боловсон хүчин, бүтцийг тодорхойлох, үйл ажиллагааны журам, заавар боловсруулах, тусгай зөвшөөрлүүдийг авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Эдгээр байгууламжийн үйл ажиллагааг эрхлэн явуулах боловсон хүчний хувьд бүрэн хүчин чадлаар нь хэвийн үйл ажиллагаа явуулахад нийт 123 ажилтантай байх бүтцийг тодорхойлсон бөгөөд өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд тус байгууламжуудын үйл ажиллагаа, засвар арчлалтыг хариуцан ажиллахад эхний ээлжинд нийт 58 инженер техникийн ажилтнуудын бүрэлдэхүүнтэй ажилласан.



Шинэ нисэх буудлын шатахууны байгууламж, тоног төхөөрөмжийн хүчин чадал, үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээтэй уялдуулан Шатахуун хангамжийн албыг нийт 57 хүний бүтэц бүрэлдэхүүнтэй байгуулах шаардлагатай байгаагаас нийт 12 инженер, техникийн ажилтны бүрэлдэхүүнтэй ажилласан.

Нисэх буудлыг үйл ажиллагаанд бэлтгэх хэсэг нь нийт 42 хүний орон тоотой ажиллаж байгаа бөгөөд нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хангах ажлын хэсэгт ажиллаж байсан 20 ажилтныг шилжүүлэн авч ажиллуулж байна. Тус хэсэг нь Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /JICA/-ын зөвлөхүүд боловсруулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө” (Action Plan)-ний хэрэгжилтийг хангаж ажилладаг бөгөөд нисэх буудлыг гэрчилгээжүүлэх, үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны журам, заавар, гарын авлагууд (нийт 5 заавар, 108 журам, тэдгээрийн дагалдах бичиг баримтууд)-ыг боловсруулж байна.

Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны алба нь 2017 онд нийт 10,370.0 сая төгрөгийн төсөвтэйгээр үйл ажиллагаа явуулахаар төсөв батлагдсан боловч төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах зарчим баримталсны үр дүнд 5,886.0 сая төгрөгийн зардлын гүйцэтгэлтэй ажиллаж, батлагдсан төсвөөс нийт 4,484.0 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажилласан болно.

Цаашид нислэг үйлдвэрлэл эхлээгүй ч гэсэн дээрх барилга байгууламжийн ашиглалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, нисэх буудлын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах үүднээс жилд дунджаар 66,100.0 сая төгрөгийн зардал /элэгдлийн зардал багтсан/ гарах урьдчилсан тооцоо гарсан.

1 дүгээр бүлгийн 23 дугаар асуудалд өөрийн чиг үүрэгт хамааралгүй зардлыг 1,706.5 сая төгрөгөөр санхүүжүүлсэн.

Аудитын дүгнэлт: Хан-Уул дүүргийн 9,10,13,16 дугаар хороодын Ахмад настан, хүүхэд багачүүдэд зориулсан амралт, чийрэгжүүлэлтийн талбай, Хүүхдийн тоглоомын талбай байгуулахад 97.8 сая тогrog зарцуулсан.

ИНЕГ-ын санал: ХУД-ийн 9,10,13,16 дугаар хороодод Иргэний нисэхийн ерөнхий газар болон түүний харьяа байгууллагуудын 335 ажилтнууд амьдардаг. 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Хан-Уул дүүрэг, Иргэний нисэхийн ерөнхий газар хооронд байгуулсан хамтын ажиллагааны санамж бичгийн 3.2.4 дэх заалт “*Нийгмийн хариуцлагын хүрээнд тулгамдаж буй асуудалд бүх талаар дэмжлэг үзүүлэх*” –д заасны дагуу ИНЕГ нь нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх зорилгоор дээрх хороодоос санал авч хүүхдийн тоглоомын талбай, ахмад настануудад зориулсан амралтын талбайг тус тус тохижуулж хүлээлгэн өгч ажилласан. Тохижилтын ажлыг “Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээг худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулсан.

2 дугаар бүлгийн 48 дугаар асуудалд

Аудитын дүгнэлт: “Чингис хаан” Олон улсын нисэх буудлыг Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудалд нүүлгэн шилжүүлэхэд барилга байгууламжийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой бус байна.

ИНЕГ-ын санал: Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/753 дугаар тушаалаар Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэхээр сургалтын төв, дэд бүтцийг бий болгох, өмнө нь ашиглагдаж байсан алслагдсан сум, орон нутгийн нисэх буудлууд, бага оврын онгоц хөөрч, буух нислэгийн зурвасыг сэргээн дахин ашиглалтад оруулах талаар ажлын хэсэг байгуулагдан ажилласан.

Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал ашиглалтад ороход Буянт-Ухаа дахь “Чингис хаан” Олон улсын нисэх буудал нь Иргэний нисэхийн дүрмийн 139.7-ийн



Аэродромын гэрчилгээжүүлэлтийн ангиллын (В)-д зааснаар одоо байгаа ангиллаас II,III,IV ангилал болгон бууруулан ашиглахад шаардлагатай тооцоо, судалгаа болон үлдэх хөрөнгийн хэмжээ, боловсон хүчин, цаашдын арчлалт, ашиглалтын зардлын судалгааг Агаарын харилцаа, агаарын тээвэрлэгчдийн үйл ажиллагааны зохицуулалтын хэлтэс, мэргэжлийн алба хэлтсүүдтэй хамтран хийж цаашид дараах чиглэлээр үйл ажиллагааг явуулах талаар санал боловсруулсан. Үүнд

1. Ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа;
2. Агаарын хөлгийн засвар үйлчилгээ;
3. Иргэний нисэхийн сургалт, дадлагын үйл ажиллагаа;
4. Улсын агаарын хөлгөөр гүйцэтгэх нислэг /цэргийн/;
5. Бүсийн агаарын хөдөлгөөний удирдлага;
6. Оношилгоо, хэмжил зүйн лаборатори;
7. Холбоо, навигаци, бодит ажиглалтын техник хангалтын үйлчилгээ;
8. Иргэний нисэхийн байгууллагын авто бааз;

“Чингис хаан” Олон улсын нисэх буудлыг шинэ нисэх буудал руу нүүлгэн шилжүүлсэн тохиолдолд одоогийн барилга байгууламжийн өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбоотой санал, тооцоо судалгааг 2018 оны 01/227 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн бөгөөд шийдвэр гарахыг хүлээн ажиллаж байна. /Дэлгэрэнгүй судалгааг хавсаргав/



Саналд өгсөн тайлбар

2018.03.23

Ирсэн саналын дугаар	Аудитын тайланд тусгасан эсэх	ҮАГ-ын тайлбар
Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 01/956 дугаартай албан бичиг	Бүлэг 1.27-д: 2014-2017 онуудад 8,587.6 сая төгрөгийн үр ашиггүй зардал гаргажээ. Үүнээс Ази, Номхон далайн бүсийн Иргэний нисэхийн ерөнхий захирлуудын 54 дүгээр хурлыг зохион байгуулахад 1,698.8 сая төгрөг зарцуулсан байна гэснийг хурлаас гарсан үр дүнг үндэслэн аудитын тайлангаас хасч байна.	Монгол Улсад Ази, Номхон далайн бүсийн Иргэний нисэхийн ерөнхий захирлуудын 54 дүгээр хурлыг зохион байгуулснаар дараах үр дүнд хүрчээ. Үүнд: ✚ Навигацийн хураамж тооцох аргачлалыг 34-96 ам.доллар байхаар нэмэгдүүлж өөрчилснийг ОУИНБ-аар хүлээн зөвшөөрүүлсэн ✚ Дээрх өөрчлөлтөөс наavigацийн орлого өмнөх оноос 19 хувиар өссөн ✚ МУ-ын иргэний нисэхийн салбарын нэр хүндийг олон улсад таниулсан ✚ Хурлын үеэр зохион байгуулагдсан уулзалт, ярилцлагын үр дүнд гадаад хамтын ажиллагаанд ахиц дэвшил гарснаар ойрын 10 жилд наavigацийн орлого 10 хувиас дээш нэмэгдэх боломж бүрдсэн гэх мэт ололт, амжилттай үр дүн гарчээ гэж дүгнэлээ.



2018.04.30

№	Саналд явуулсан хувилбар	Саналд тусгасан эсэх	Саналыг тусгасан хувилбар
1.22	Ямар ч хууль, эрх зүйн үндэслэлгүйгээр “МИАТ” ХК, “Хүннү Эйр” ХХК, “Аэромонголиа” ХХК-иудын нислэгийн нөхөн олговорт 301.1 сая төгрөг зарцуулсан.	үгүй	Уг зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
1.22	“Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал”-ын барилга, байгууламж ашиглалтад орж, үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байхад түүнтэй холбоотой ашиглалтын болон урсгал зардалд 2017 онд 5,886.0 сая төгрөг зарцуулсан.	үгүй	Энэ зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
1.23	Хан-Уул дүүргийн 10, 16 дугаар хороодын “Ахмад настан, хүүхэд багачуудад зориулсан амралт, чийрэгжүүлэлтийн талбай” байгуулахад 48.9 сая, Хан-Уул дүүргийн 9, 13 дугаар хороодын “Хүүхдийн тоглоомын талбай” байгуулахад 48.9 сая төгрөг тус тус зарцуулсан.	үгүй	Энэ зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6.1-т “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 14.2.3-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 6.6.6-т “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.
2.48	“Чингис хаан” ОУНБ нь “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-д нүүлгэн шилжүүлэхэд Иргэний Нисэхийн ерөнхий газраас одоогийн барилга байгууламжийн цаашдын эзэмшил, ашиглалтын талаарх /ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа, иргэний нисэхийн сургалт, дадлагын үйл ажиллагаа, бүсийн агаарын хөдөлгөөний удирдлага, тусгай үүргийн нислэгийн төв бий болгох/ санал, тооцоо судалгааг боловсруулан 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01/227 дугаартай албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн ч цаашид барилга байгууламжуудыг хэрхэн ашиглах тодорхой чиглэл гараагүй байна.	үгүй	Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30.2-т “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгө, хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад хөдлөх хөрөнгийг Засгийн газрын шийдвэрээр, Засгийн газраас зөвшөөрөл олгосон тохиолдолд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрээр шилжүүлж болно...”, 30.3-т “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэсэн заалт зөрчигдөх, төрийн өмч хөрөнгө завшигдах, шамшигдах эрсдэлтэй байгаа тул өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.



Тайланг баталгаажуулсан Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/129

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалт, мөн 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016-2017 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Эдийн Засгийн Байнгын хороо, Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам, Иргэний нисэхийн ерөнхий газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2019 оны нэгдүгээр улиралд Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд /Ж.Бат-Эрдэнэ/, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга /Л.Бямбасүрэн/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газар /М.Давааням/-т даалгасугай.

5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажсанаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивт хүлээлгэн өгөхийг аудитын баг /И.Туяа/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ХҮРЭЛБААТАР



Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дугаар т/шаалын хоёрдугаар хавсралт 2/29

Аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалт

УХА0122

/сая.төг/

№	Хариуцагч байгууллага	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дугаар	Зөрчлийн дүн
1	Зам, тээврийн хөгжлийн яам	Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төслийн ажлын гүйцэтгэл 99.95 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Ачаа шуудан тээврийн, Захиргааны болон Аэродромын үйлчилгээний барилга" ажлыг гүйцэтгэхээр захиалагч Зам, тээврийн хөгжлийн яам, гүйцэтгэгч "Ви Эйч энд Би" ХХК-ний хооронд анх 2016 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр 113/14 дугаартай гэрээг байгуулж, нэмэлт гэрээг 2 удаа хийж, барилга угсралтын ажлыг 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгагдсанаас шинэ нисэх буудлын ашиглалтад эцэслэн оруулах хугацаа хойшлогдсон байна. Гэтэл Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ нисэх буудлын барилга, байгууламж ашиглалтад ороогүй, үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байхад 2017 онд шинэ нисэх буудлын ашиглалтын болон үйл ажиллагаатай холбоотой үр ашиггүй зардал гарчээ.	02/200	6,133.8
2	Зам, тээврийн хөгжлийн яам	Зам, тээврийн сайдын /хуучин нэрээр/ 2015 оны 340, 341 дүгээр тушаалуудаар "Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах алба"-г яамны бүтцэд байхаар баталж, харин Иргэний нисэхийн ерөнхий газарт "Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба"-ны үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу санхүүжүүлж ажиллахыг даалгасан байна. Үүний дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтэц, орон тоонд хамааралгүй албаны үйл ажиллагааг 2015-2017 онуудад санхүүжүүлсэн байна.	02/201	1,214.8
3	Иргэний нисэхийн ерөнхий газар	Бүсийн нислэгийн хөдөлгөөний төвийн барилгын ажлыг захиалагч Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам /хуучин нэрээр/, гүйцэтгэгч "Үүрэг трейд" ХХК-тай 2011 оны 06 дугаар сарын 30-ний өдөр ИНЕГ/ТББ/БУ-47/10/93 дугаартай /гэрээний нийт үнэ 6,759.5 сая төгрөг/ гэрээг анх байгуулж, 2013 оны 04 дүгээр сарын 01-ны өдөр гэрээний нэмэлтийг хийж, ажлыг 2013 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ашиглалтад оруулахаар заасан ч гүйцэтгэгч гэрээний хугацаанд ажлаа хийж дуусгаагүй, захиалагчаас гэрээг дүгнээгүй, гүйцэтгэгч "Үүрэг трейд" ХХК-д улсын төсвөөс ажлын гүйцэтгэлд 6,034.8 сая, ИНЕГ-аас шүүхийн 1463 дугаар тогтоолын дагуу үнийн өсөлт, нэмэгдэл ажилд 3,809.6 сая төгрөгийг тус тус олгосон, барилгын ажил 2014 оны 5 сараас хойш зогсонги байдалд орсон, цаашид уг барилгын ажлыг үргэлжлүүлэх эсэх нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.	01/187	6,034.8
Дүн				13,383.4



Хавсралт

Хавсралт №1

Агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагыг гэрчилгээжүүлсэн судалгаа.

№	Агаарын тээвэрлэгчийн нэр	АТГ-ний дугаар	ИНД	Анх олгосон огноо	Сунгасан огноо	Хүчинтэй огноо	Иргэний агаарын тээвэрлэлтийн үйл ажиллагааны төрөл
1	“МИАТ” ХК	АТ-003	121-баг таамж ихтэй онгоц	1997.02.21	2017.08.21	2020.05.21	зорчигч, ачаа тээвэрлэлт, шуудан тээвэрлэлт, дадлага, сургалтын, захиалгат, онцгой үүргийн нислэг
2	“Аэро Монголиа” ХХК	АТ-009		2003.06.03	2016.05.17	2019.05.16	
3	“Хүннү Эйр” ХХК	АТ-018		2011.11.17	2016.09.20	2018.11.17	
4	Монголын Алт "МАК" ХХК	АТ-014	135- баг- таамж багатай онгоц, нисдэг тэрэг	2008.06.09	2016.06.22	2019.06.21	зорчигч, ачаа тээвэрлэлт, дадлага сургалтын нислэг, эмнэлгийн түргэн тусламжийн, эрэн хайх, авран хамгаалах нислэг, онцгой үүргийн нислэг
5	“А-Жэт Авиэйшн” ХХК	АТ-015		2000.04.19	2016.06.01	2019.05.31	зорчигч, ачаа тээвэрлэлт, дадлага сургалтын нислэг, эмнэлгийн түргэн тусламжийн нислэг, эрэн хайх, авран хамгаалах нислэг, захиалгат нислэг, онцгой үүргийн нислэг
				2008.06.24			
6	“Блу Скай Авиэйшн” ХХК	АТ-017		2000.08.18	2017.10.13	2018.10.12	зорчигч, ачаа тээвэрлэлт, дадлага сургалтын нислэг, эмнэлгийн түргэн тусламжийн нислэг, эрэн хайх, авран хамгаалах нислэг, захиалгат нислэг
7	“Геосан” ХХК	АТ-019		2006.04.13	2017.11.06	2017.11.05	зорчигч, ачаа тээвэрлэлт, захиалгат нислэг, агаараас зураг авах, дадлага сургалтын нислэг, геофизикийн судалгааны нислэг
8	“Томас Эйр” ХХК	АТ-021		2011.05.25	2015.11.25	2018.11.25	зорчигч, ачаа тээвэрлэлт, эмнэлгийн түргэн тусламж, , захиалгат, эрэн хайх авран хамгаалах, агаараас зураг авах, шүхэр буулгах
9	“Вельталь Авиастар” ХХК	ХАА-05	137-ХАА-н зориулалт	2016.04.19	2017.04.19	2018.04.18	хөдөө аж ахуйн нислэг
10	“Топ Экстрим Экшин Монголиа” ХХК	МСАА.14 9. 01.17	149- нисэх клуб	2015.08.24	2017.09.14	2018.09.13	нисэх клубын үйл ажиллагаа, нислэгийн сургалт, гэрчилгээ олгох, зөвхөн албан ёсны клубын гишүүд нислэгийн үйл ажиллагаанд оролцох

Хавсралт №2

Монгол Улсад арилжааны зорилгоор агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах гадаадын агаарын тээвэрлэгчийг гэрчилгээжүүлсэн судалгаа.

д/д	Гадаадын агаарын тээвэрлэгчийн нэр	Гэрчилгээний дугаар	Олгосон огноо	Хүчинтэй огноо	Монгол улс руу нислэг үйлддэг агаарын хөлгийн маяг - тоо
1	Аэрофлот	FAOC-001	2015.12.08	2018.03.01	A320 - 75
					A321 - 38
					B737 - 36
2	Кореан Эйр	FAOC-002	2013.03.07	2018.03.12	A300 - 8
					A330 - 30
					B737 - 46



3	Эйр Чайна	FAOC-003	2013.04.19	2018.04.19	B737 - 78
4	Тяньжин Эйрлайнз	FAOC-005	2016.07.01	2019.06.30	Embraer ERJ 190 - 39
5	Турк Эйрлайнз	FAOC-006	2018.02.01	2023.01.31	A321 - 43
					A320 - 33
					B737 - 88
6	Янци Ривер Экспресс	FAOC-009	2015.09.15	2018.09.14	B737 - 20
7	Эйр Бусан	FAOC-012	2017.10.16	2020.10.15	A320 - 6
					A321 - 17
8	Ангара Эйрлайнз	FAOC-013	2017.09.22	2018.09.21	Ан148 - 5

Хавсралт №3

Агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлтийн нэгтгэсэн судалгаа

№	Байгууллагын нар	ИНД	Үйл ажиллагаа, үйлчилгээний төрөл	Гэрчилгээ олгосон огноо	Хүчинтэй огноо
1	Техник хангалт, үйлчилгээний алба	171	агаарын навигацийн ATIS, AWOS, AFTN, AEL, DF, HFA-G, VHFA-G, VOR, DME, ILS, NDB, шууд ярианы хэлхээ, маркер, ATSMHS, PAPI, SSR, ADS-B	2015.10.16	2019.10.16
2	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний алба	172	нислэгийн хөдөлгөөний TWR, ACC, FIS, APP, AFIS, ALERT, RADAR	2015.05.29	2019.06.10
3	Нислэгийн журам, үйлчилгээний байгууллага,	173	Шалгалтын нислэг, зураглалын алба	2015.04.24	2019.04.25
4	Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба	175		2014.07.04	2019.07.05

Хавсралт №4

Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ эзэмшигч байгууллага, агаарын хөлгийн судалгааны нэгтгэл

№	Агаарын тээвэрлэгч байгууллагын нэр	Агаарын хөлгийн маяг	Агаарын хөлгийн төрөл	Бүртгэсэн огноо	Олгосон огноо	Хүчинтэй хугацаа
1	"МИАТ" ХК	JU-1015	B737-800	14.05.06	17.05.30	18.05.31
		JU-1021	B767-300ER	13.05.11	17.06.19	18.06.19
		JU-1087	B737-700	17.05.29	17.05.31	18.04.30
2	"Аэромонголиа" ХХК	JU-8258	Fokker 50	03.05.02	18.02.06	19.02.05
3	"А-Жет Авиэйшн" ХХК	JU-5598	MBB-BK 117 C-2	11.10.28	17.10.06	18.10.05
4	"МАК" ХХК	JU-6600	МИ-8АМТ	11.10.13	17.11.02	18.11.01
		JU-6601		08.03.04	17.09.14	18.09.14
5	"Хүннү эйр" ХХК	JU-8801	ATR 72-212A	16.07.08	17.10.03	18.10.02
		JU-8802	ATR 72-212A	17.06.09	17.06.09	18.06.06
		JU-8883	Fokker 50	13.07.26	17.07.06	18.07.05
6	"Геосан" ХХК	JU-9991	CESSNA 208B	07.07.05	17.03.30	18.03.30
		JU-9993		09.06.29	17.03.30	18.03.30
7	"Блу Скай Авиэйшн" ХХК	JU-2114	CESSNA 208B	11.04.21	17.03.13	18.03.13
8	"Томас эйр" ХХК	JU-1911	King Air C90	17.11.24	18.02.12	19.02.11
		JU-1918	Airtractor AT602	12.07.04	17.11.30	18.11.30
9	"Вэльталь-авиа Стар" ХХК	JU-9069	AH-2	13.04.26	18.02.07	19.02.06

Хавралт № 5

2007-2017 оны хооронд агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн нэгтгэсэн судалгаа

№	Тээвэрлэгчийн нэр	Нисгэгчийн эрх			
		Агаарын тээвэрлэгчийн нисгэгч	Коммерийн нисгэгч	Маягийн зэрэггүй, зөөгдөж байгаа	Нийт
1	"МИАТ" ХК	15	18	5	33
		12	10		22
		27	28		60
2	"Аэро Монголиа" ХХК	10	12	4	22
		10	12		22
		4	3		7
3	"Хүннү Эйр" ХХК	3	6	4	9
		7	9		20
		2	1		3
4	Монголын Алт "МАК" ХХК	2	1		3
5	"А-Жэт Авиэйшн" ХХК	1	1		2
6	"Геосан" ХХК	2	3		5
7	"Томас Эйр" ХХК		2		2
8	"Вэльталь Авиа Стар" ХХК	1	2		3
	Нийт дүн	94	107	18	210



Хавсралт № 6 Аудитаар илэрсэн зөрчлийн хуудас

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Хууль эрх зүйн үндэслэл	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Албан тушаал	Овог нэр
А	3	4		5	8	9
1	ИНЕГ нь 2008-2012 онуудад ажилтнууддаа 14,034.5 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг олгосон ба ХХОАТТ хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу хувь хүнээс орлогын албан татвар суутгаагүйн нөхөн төлбөр, түүний алдангийг шүүхийн шийдвэрээр авсан.	1,444.7	Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дах заалт	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	С.Батмөнх Д.Алтанцэцэг
2	2014-2016 онуудад ажилгүй байсан хугацааны цалин болон буцаан томилогдсон 23 хүний нөхөн олговор, НДШ болон ХХОАТатварт шүүхийн шийдвэрээр авсан.	614.4	Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Т.Лхагвасүрэн Ц.Эрдэнэбилэг Г.Нямдаваа М.Энхмаа
3	Захиргаа, хүний нөөцийн газарт менежер хийж байсан Д.Эрдэнцогтод 2017 оны 01 сарын 16-ны өдрийн шүүхийн шийдвэрээр орон сууцны хөнгөлөлт гаргуулж авсан.	110.8	Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга ИНЕГ-ын санхүү, төлөвлөлтийн ерөнхий менежер Ерөнхий нягтлан бодогч	С.Батмөнх Г.Наранцэцэг Д.Алтанцэцэг
4	“Үүрэг трейд” ХХК 2013 онд гэрээний ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэмэгдэл ажил, үнийн өсөлтийн зөрүүг шүүхийн шийдвэрээр авсан.	3,829.1	Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга ИНЕГ-ын санхүү, төлөвлөлтийн ерөнхий менежер	С.Буяндалай Г.Наранцэцэг
5	Бүсийн нислэгийн хөдөлгөөний барилга, байгууламжийг барихаар “Үүрэг трейд” ХХК гэрээ байгуулсан ба улсын төсвөөс ажлын гүйцэтгэлд 2011-2013 онуудад санхүүжилт авсан боловч гэрээний хугацаанд ажлаа хийж дуусгаагүй, одоог хүртэл гэрээгээ дүгнээгүй байна.	6,034.8	Иргэний тухай хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.1, 351 дүгээр зүйлийн 351.1.2 дах заалтууд	ИНЕГ-т Албан шаардлага, Авилгатай тэмцэх газарт шилжүүлэх	ЗТБХБЯ-ны зам, тээврийн бодлогын газрын дарга ЗТБХБЯ-ны санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга ЗТБХБЯ-ны сайдын багцын ерөнхий нягтлан бодогч ИНЕГ-ын дарга ИНЕГ-ын санхүү, төлөвлөлтийн ерөнхий менежер	Б.Махбал Ё.Манлайбаяр З.Цэрэнчимэг С.Батмөнх Г.Наранцэцэг
6	Монгол Улсад нисэх хүчин үүсч хөгжсөний 92 жил, ИНЕГ-ын 60 жилийн ой, Иргэний нисэхийн холбооны салбар үүсч хөгжсөний түүхт 70 жилийн ой, нисэхийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөг хийх, төрөл бүрийн тэмцээн зохион байгуулах зэрэгт 2016-2017 онуудад гарсан зардал.	320.5	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхшиг Н.Наранцэцэг
7	Улаанбаатар хотноо 2016 онд АСЕМ-ийн дээд түвшний 11 дэх уулзалтыг зохион байгуулахад ИНЕГ-аас оролцсон ажилтнуудад	32.7	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Нямдаваа А.Дагвадорж Н.Наранцэцэг



	урамшуулалт цалин олгосон.					
8	Дээрх уулзалтыг зохион байгуулахад оролцсон ажилтнуудад хүндэтгэл үзүүлсэн.	18.4	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
9	ИНЕГ-ын 2016-2017 оны үр дүнгийн тайлангийн хурлын үйл ажиллагаа зохион байгуулахад гарсан зардал.	67.6	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
10	ИНЕГ-т хууль эрх зүйн газар ажиллаж байгаад 2016 онд бүтцийн өөрчлөлтөөр татан буугдаж 2017 онд хуулийн мэргэжилтэн ажиллаж байгаа боловч 2014-2016 онуудад гадны байгууллагаас хууль эрх зүйн үйлчилгээ авсан.	245.1	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Т.Лхагвасүрэн Ц.Эрдэнэбилэг Г.Нямдаваа А.Дагвадорж М.Энхмаа
11	ОУИНБ-ын Ази, Номхон далайн бүсийн орнуудын Иргэний нисэхийн ерөнхий захирлуудын 54 дүгээр чуулганы арга хэмжээнд 2017 онд гарсан зардал.	85.0	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
12	“Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх буудал”-ын барилга, байгууламж ашиглалтад орж, үйл ажиллагаагаа эхлүүлээгүй байхад, 2017 онд түүнтэй холбоотой гарсан зардал.	5,886.0	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Зам, тээврийн хөгжлийн яаманд Албан шаардлага	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
	Олон улсын шинэ нисэх буудлын халаалтын зардал төлөгдөөгүй төлбөр, түүний алдангийг 2017 онд шүүхийн шийдвэрээр гаргуулж авсан.	247.8	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Зам, тээврийн хөгжлийн яаманд Албан шаардлага	ИНЕГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Н.Наранцэцэг
13	Зам, тээврийн хөгжлийн яамны зарим ажилтнуудын 2016-2017 оны гадаад, дотоод томилолтонд гарсан зардал.	148.5	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
14	Зам, тээврийн хөгжлийн яамны нэр бүхий албан тушаалтнуудын 2016-2017 онд суудлын автомашин ашигласан зардал.	209.6	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
15	Хан-Уул дүүргийн 10, 16 дугаар хороодын “Ахмад настан, хүүхэд багачуудад зориулсан амралт, чийрэгжүүлэлтийн талбай” байгуулах зардлыг 2017 онд санхүүжүүлсэн.	48.9	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
16	Хан-Уул дүүргийн 9, 13 дугаар хороодын “Хүүхдийн тоглоомын талбай” байгуулах зардлыг 2017 онд санхүүжүүлсэн.	48.9	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
17	2017 онд тавилга, эд хогшил худалдан авсан.	28.8	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.3	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг



18	2017 оны цэвэр ашгаас Моннис Моторс ХХК-аас “Ниссан теана” маркийн суудлын автомашин 3 ширхгийг худалдан авсан.	170.7	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.3	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
19	2017 оны цэвэр ашгаас Моннис Моторс ХХК-аас “Ниссан патрол жийп” маркийн суудлын автомашин 2 ширхгийг худалдан авсан.	376.2	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дугаар зүйлийн 24.3	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
20	2015-2017 онуудад ЗТХЯ-ны 3 ажилтанд орон сууцны хөнгөлөлт олгосон.	35.8	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
21	“Орон сууцны хөнгөлөлт олгох журам”-ийн шалгуур үзүүлэлт хангаагүй 1 ажилтанд, мөн давхардуулан 1 ажилтанд 2017 онд орон сууцны хөнгөлөлт олгосон.	42.0	“Орон сууцны хөнгөлөлт олгох” журамын 2.1.1, 2.2.1 дэх заалтууд	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Нямдаваа А.Дагвадорж Н.Наранцэцэг
22	“Гүрэн” дээд сургуульд сургалтын төлбөрийг 2017 онд шилжүүлсэн.	512.0	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга ХААХ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Б.Батхишиг Н.Наранцэцэг
23	ИНЕГ-ын бүтэц, орон тоонд тусгагдаагүй албаны үйл ажилллагааг 2016-2017 онуудад санхүүжүүлсэн.	1,214.8	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Зам, тээврийн хөгжлийн яаманд Албан шаардлага	ИНЕГ-ын дарга СЭЗХ-ийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Ч.Нямсүрэн Н.Наранцэцэг
24	ИНЕГ-ын салбарын хэмжээнд 2017 онд акталж, устгах хөрөнгүүд байна.	370.6	Төрийн өмчийн хорооны 2009 оны 19 дүгээр тогтоол	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Н.Наранцэцэг
25	Завхан аймгийн “Доной” нисэх буудлын онгоц хөөрч буух хатуу хучилттай зурвас, үерийн далан барих 2017 оны ажлын гэрээг сунгасан эсэх, байгууламжийг хэзээ дуусгах нь тодорхойгүй байна.	10,894.0	Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд байгуулсан дугаар № ИНЕГ.ТББ/БУ-56-07 тоот гэрээний нэмэлт өөрчлөлт /2017.07.05/	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Н.Наранцэцэг
26	“Чингис хаан” ОУНБ-ыг “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал”-д нүүлгэн шилжүүлэхэд барилга байгууламжийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаарх асуудал тодорхой бус байна.	100,093.6	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2, 30.3 дах заалтууд	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Н.Наранцэцэг
27	Ховд аймгийн Ховд нисэх буудлын аэродромын урсгал засварт 2014-2017 онуудад төлөвлөгөөнөөс гадуур зардал гаргасан.	48.2	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Зөвлөмж	ИНЕГ-ын дарга СХОГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Г.Нямдаваа А.Дагвадорж Н.Наранцэцэг
28	Капитал банкаар дамжуулан гүйлгээ хийгдсэн навигацийн орлогын хувьд, “Чингис хаан” ОУНБ-ын капитал банкны 2061002679 дугаартай данснаас 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдөр навигацийн орлого 2,000.0 сая төгрөгийг Сангийн яамны Төрийн	2,000.0	Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5	Авилгатай тэмцэх газар шилжүүлэх	“Чингис хаан” ОУНБ-ын захирал Ерөнхий нягтлан бодогч	Д.Мөнхбаатар Г.Халиунбигэр



	сангийн 100900000707 дугаартай данс руу шилжүүлсэн боловч 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдөр "Чингис хаан" ОУНБ-ын санхүү, Сангийн яамны Төрийн сантай тооцоо нийлэхэд дээрх орлого дансанд ороогүй Капитал банкинд саатуулагдсан байна.					
29	Гадаадын Их, дээд сургуулиудад гэрээгээр тэтгэлэгт хамрагдсан оюутнуудын судалгааг 2016- 2017 оны байдлаар гаргуулж авахад сургалтын журамгүй, тодорхой шалгуур үзүүлэлтгүй, сонгон шалгаруулалтгүйгээр 38 хүнтэй шинээр сургалтын гэрээ байгуулснаас 24 хамааралгүй хүмүүс байна.	1,223.9	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1	Авилгатай тэмцэх газар шилжүүлэх	ИНЕГ-ын дарга Ерөнхий нягтлан бодогч	Л.Бямбасүрэн Н.Наранцэцэг
Нийт дүн		136,403.4				

